

**Шарын шашны хутагт хувилгаад тодруулах ёсон ба  
геополитикийн интервенц**

**Удо Б. Баркманн**  
(МСТ-ийн зочин профессор)

**Түүхэн урьдач нөхцөл**

1640 онд Халх, Ойрадын ноёд Баруун Монголын Тарвагатайн нутаг хэмээх газар хуран цуглаж, хүчирхэгжин буй Манж гүрний эсрэг нэгдсэн холбоо байгуулах нөхцөл боломжийн талаар хэлэлцэх үед уг чуулганд мөн Ойрад болон Халх Монгол дахь Далай ламын элч төлөөлөгч болох Манзушри хутагт, Цагаан номын хан нар оролцжээ. Шарын шашны том зүтгэлтэн төдийгүй нэр алдар нь ихэд түгсэн эрдэмтэн лам Зая Бандид Намхайжамц /1599-1662/ Баруун Монголоос мөн залран ирсэн байлаа. Баруун Монголын нөлөө бүхий Баавхан ноёны хүү Намхайжамц нь Төвдийн шарын шашны дацан хийдэд хориод жил шавилан сууж, бүрхны номонд нэвтэрхий боловсроод номч мэргэн хэмээгдсэн нэгэн байлаа.

Хаад ноёд дээрхи чуулганд оролцохдоо шарын шашны мяндагтан лам нарын нэгэн адилаар мөн нэг талаар эрх мэдлээ нэмэгдүүлэх, сүр хүчээ тэлэх завшаан хайж байлаа. Уг чуулганд Монголын ноёд Манжийн эсрэг нэгдсэн холбоо байгуулахыг эн тэргүүнээ зорьж байх чухам энэ үед лам нар харин геополитикийн гэж бараг хэлж болохуйц сонирхлоо хэрэгжүүлэх тухай л бодож байв. Манжийн хаад шарын шашинд анхнаасаа л ээлтэй хандаж байсны учир лам нарын хувьд бараг аюултай биш байсан болов уу. Харин ч Халх Монголд шарын шашныг улам хүчтэй дэлгэрүүлэх таатай боломжийг лам нар олж харсан бөгөөд Тарвагатайн нутагт хуралдсан ноёдын чуулган нэгэн сонирхолтой хандлагыг бий болгосон. Тухайлбал даяар монголчууд бүгдээрээ заавал дагаж мөрдөх ёстой цаазын бичгийг хэлэлцэн гаргахаар чармайлт тавьж байсан нь лам нарт тун дөхөмтэй байлаа. Зөвхөн лам нар бичиг номын хүмүүс байсныхаа хувьд уг чуулганы үеэр хууль цаазын бичгийг найруулан бичихэд гол нөлөөг үзүүлж чадсан юм. Бүх монголчууд бултаараа зайлшгүй дагах ёстой цаазын бичиг нь шарын шашны үзэл сургаалыг монголчуудын амьдралд гүн бат оруулж өгөх хамгийн таатай нөхцлийг бий болгосон юм.

Зая Бандид уг чуулганы дараа Засагт ханы заллагаар Халх Монголд морилон саатсан бөгөөд тэрээр Монголын энэ чухал нутагт шарын шашныг дэлгэрүүлэн мандуулах үйлс зогсонги байдалд ороод байсныг дахин сэргээх хүсэл давхар өвөрлөж байв. Далай лам 1614 онд төвдийн эрдэмтэн лам Майдар хутагтыг шарын шашныг дэлгэрүүл хэмээн Халх Монгол уруу явуулсан байна. Тэрээр Халх Монголд 1634 /1635?/ онд таалал төгсөх хүртлээ тэнд олон жил суужээ.

Зая Бандидыг залран ирэхэд Халх Монголын хамгийн том ноёд болох Түшээт хан, Сэцэн хан нар түүнийг хүлээн авсан. Эдгээр хаадыг их улс гэрийг нэгэнтээ үүсгэн байгуулж асан Чингис хааны /1162-1227/ удмын онцгой нөлөө бүхий хаад хэмээн үздэг байлаа. Иймд эртний монгол хаадын ордон харш сүндэрлэн байсан Хархорумын туурь балгас бүхий нутгийг захиран суусан Түшээт ханы нугун үр л 1640 онд Майдар хутагтын залгамжлагч болон Халх Монголын шашны тэргүүнээр /?/ өргөмжлөгдсөн нь санамсаргүй явдал байж боломгүй мэт.

Дээр өгүүлсэн түүх улс төрийн далд санаа агуулагдаагүй гэх аргагүй тул зарим нэг тайлбар хийх шаардлагатай юм. Улс төрийн овсгоо сайтай Сэцэн хан бээр Занабазарыг мэндлэхийн өмнө Түшээт ханыд айлчилжээ. Тэрээр айлчлах үедээ хэлсэн нь: "Тэнгэр язгуурт Чингис хааны алтан ургийн хөвгүүн, бид бүгдийн эзэн болох нэгэн сайн хүү Халхын хан, ван, ноёдын эртний сайн ерөөлийн хүчээр танайд мэндлэх юм байна гэж миний санаанд байнга буух боллоо."<sup>1</sup> Сэцэн ханы зөгнөн хэлсний дараахан буюу 1635 онд Занабазар мэндэлж, гурван наснаасаа тарнийн ном унших болсон гэх агаад тоглохдоо ч хүртэл буян номын газар болох дуган хийдийн /Эрдэнэ Зуу хийд байж магадгүй/ ойролцоох газрыг сонгодог байсан тухай түүхэн шастир бичигт дурдсан байдаг. Түүнд 1638 онд Увш сахил хүртээж, 1640 онд Зая Бандидыг Халх Монголд саатах тэр үед Халх Монголын хамаг ноёдыг цуглуулан тийн гарсан (равжүн)-ы сахил хүртээж, Дамбийжанцан /буюу Лувсандамбийжалцан/ хэмээх сахилын нэрийг хайрлажээ. Гэвч тэрээр судар шастирт Өндөр Гэгээн Занабазар гэдэг нэрээрээ алдаршсан юм. Дээрхи сахил хүртээх ёслолд Халх Монголын хамаг ноёд хүрэлцэн ирсэн нь уг ёслолын ажиллагаа зохион байгуулалттай байсныг харуулж байна. Занабазар 1649 онд Төвд орноо морилж очоод, 1650 онд Банчин ламаас гэцэл сахил хүртсэн бөгөөд мөн тэр үед 5-р Далай лам түүнийг Дарнад-Жавзандамбын хувилгаан дүр болохыг тодруулжээ. Халх Монголын Жавзандамба ингэхэд ер нь чухам хэний хувилгаан дүр байв гэдгийг ойлгоход бэрх хэмээн английн эрдэмтэн Бауден тун зүйтэй үзжээ.<sup>2</sup> Учир нь Жавзандамбын удаахь дүрүүд өөрийгөө Майдар хутагт хэмээсэн нь 4-р Далай ламын Монголд элч төлөөлөгчөө болгон явуулсан 1-р Майдар хутагтын хойд дүр гэж түүнийг таамаглан үздэгтэй илүү дөхүү юм. Гэсэн хэдий ч энэ нь түүхэн баримт сурвалжаар бараг нотлогдоогүй зүйл билээ.

Сэцэн хан, Түшээт хан нар олон ноёдыг урьж Халх Монголын шашны тэргүүнээр Занабазарыг өргөмжлөхдөө цаанаа ямар бодлыг агуулж байв? Тэд шарын шашны сүсэгтэн нар бараг байгаагүй, гэвч тэдэнд Зая Бандидын нэр нөлөө, шашны сүр хүч магадгүй ихээхэн сэтгэгдэл төрүүлсэн байх. Урд зүгт Манж гүрэн хүчирхэгжин буйн улмаас халх монголчууд юу хийх шаардлагатай болов? Тэд үндэс угсаа, овог аймгаа нэгтгэх хэрэгтэй байсан, хэдийгээр ханыхаа өмнө ноёд алба хүлээдэг байсан ч ноёд харьцангуй бие даасан байдалтай болсны улмаас тэднийг ингэж нэгтгэнэ гэдэг боломжгүй зүйл байлаа. Харин нэгэн шашнаар зангидан нэгтгэх нь хавьгүй илүү боломжтой байв. Халх монголчуудыг шарын шашнаар холбож нэгтгэхэд "Чингис хааны алтан ургийн"-хан их улсыг удирдах тавилангаа анхнаас нь зөв ашиглахаас л энэ асуудлын хувь заяа шийдэгдэх байлаа. Чингис хаан монголчуудын хувьд үлгэр дууриал болсон Их Хаан байснаас гадна "бурхны номыг дэмжин тэтгэгч, ивээн хамгаалагч" хэмээгддэг байсан нь тухайн нөхцөл байдалд дөхөм болох байлаа.<sup>3</sup> Дарнат Жавзандамбын хувилгаан дүрээр ханы хүү тодорсноор Чингисийн удмынхны их улсыг удирдах тавилан хаа нэгтээ ямар нэг аргаар хутагт хувилгаадын дунд орж ирсэн. Жавзандамба хутагтыг ихэс ноёд анхнаасаа л туйлын ихээр дэмжиж хүлээн зөвшөөрсөн юм. Ноёд түүнд албат иргэд, адуу мал өргөж байсан бөгөөд энэ нь Жавзандамба хутагтын хожмын зартай их хөрөнгө сангийн уг үндэс нь болсон юм.

Халх Монголын 1-р Жавзандамба буюу Өндөр Гэгээн Занабазар бээр Баруун Хүрээ, Шанхын Хүрээ, Хэрлэнгийн Зүүн Хүрээ мөн хожмын нийслэл хот Их Хүрээний сүм хийдүүдийг байгуулсан бөгөөд ихэс ноёд түүнд шавь ард, мал хөрөнгө, бэлчээр нутгийг ч өргөл болгон барьж, ашдын буяныг үйлдэж байлаа. Манжийн хаад ч мөн энэ байдлыг улам өөгшүүлж, алба татварын хувьд сүм хийдэд тусгай нөхцөлийг эдлүүлж байв. Занабазар "гучин зургаан жилийн турш үргэлжилсэн бясалгал"-аа төгсгөөд 17-р зууны 70-аад оны эхээр соёмбо үсгийг зохиосон бөгөөд Монголын өнөөгийн төрийн далбаан дээр намирч байх соёмбо үсэг эртний бэлэгдэл ёсоор Монголын төр маш бөх, шашин маш арвин, олноороо эвтэй байхыг бэлэгшээж байна. Жавзандамба богино хугацааны дотор Далай лам, Банчин Эрдэнэ нартай бараг эн дүйцэхүйц шарын шашны хутагт лам болсон ажээ. Лхасын дээд багш лам нараас ангид шарын шашны төвийг Халх Монголд байгуулах гэсэн санаа зориг Жавзандамбад түүний өвөг дээдсээс уламжлагдан хэр зэрэг шингэсэн байв гэдгийг наанадаж судалж үзүүштэй юм. Өндөр Гэгээн Занабазарын эцэг Түшээт ханы харъяа нутагт 1586 онд үндэслэн байгуулсан Эрдэнэ Зуу хийд

<sup>1</sup> *The Jepsundamba Khutukhtus of Urga*, Text, Translation and Notes by Charles R. Bawden, in *Asiatische Forschungen* Bd. 9, Wiesbaden 1961, 8-р тал

<sup>2</sup> Мөн тэнд, 8-р зүүлт, 45-р тал.

<sup>3</sup> K. Sagaster, *Identität im Tibetischen Buddhismus, in Religion und Identität*. Im Horizont des Pluralismus. Hrsg. v. W. Gephart und H. Waldenfels, Frankfurt a. Main 1999, 189-р тал.

бүх л хугацааны туршид Халх Монголын 1-р Жавзандамбын хувьд онцгой бэлэг дэмбэрэлтэй газар байлаа. Олон зууны тэртээ-дэлхийн талыг эзлэн оршсон Монголын их гүрний хаадын ордон харш хажууханд нь оршин байсан энэхүү газарт Чингисийн удмынхны их улсыг, удирдах тавилан, шарын шашныг мандуулах гэсэн хүсэл санаа хоёр өвөрмөц байдлаар хоорондоо холбогдсон юм. Шарын шашныг дэмжин тэтгэгч Автай Сайн Хан, Түшээт Хан Гомбодорж<sup>4</sup> нарыг мөн эл газарт нутаглуулжээ.

Өндөр Гэгээн Занабазарын дараа Жавзандамбын хувилгаан дүрээр Түшээт Хан Чахундоржийн ач хүү болох Чин ван Дондовдоржийн дөтгөөр хүү тодорчээ.<sup>5</sup> Үүнээс үзэхэд Чингисийн удмын Түшээт ханыхан Жавзандамбын "хувилгаан дүрийг" цаашид ч гэр бүлийн хүрээнээсээ тодруулж байх нь тодорхой байлаа. Бээжин дэх "Гадаад мужийг засах яам"/Li-fan-yaan/-наас Монголын ноёдын талаар нэгд нэгэнгүй нямбайлан хөтөлдөг угийн бичиг "Илтгэл шастир"-аас үзэхэд 1741 онд Манжийн Тэнгэрийн тэтгэсэн /Qianlong/ хааны зарлигаар их хувилгааныг хамгаалуулахаар Дондовдорж, Түшээт Хан Дондандорж нар Жавзандамбын өргөө байрлах Их Хүрээний зүг явж байжээ гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Жавзандамбын хувилгаан дүрүүд Түшээт ханыхны гэр бүлийн хүрээнээс тодорсоор буйд Манжийн хааны ордныхон улам эвгүйцэж байлаа. Энэ хугацаанд Жавзандамбын нөлөөн дор умард Монголд бүхэлд нь тархсан 65 хүрээ хийд, тун олон дуган сүм, чөлөөтэй хэрэн бадарчлах лам нар багтах болсон байлаа. Хошууны засаг ноёдыг томилох, аймаг хошуудыг дахин жижиглэн хуваах замаар хаад, ноёдын хүчийг сулруулах, өөрийн харъяат газраа зөвшөөрөлгүйгээр орхин явахыг хориглох зэрэг засаг захиргааны арга хэмжээнүүдийг Манжийн хаан сүүлийн жилүүдэд авах болсноор ихэс ноёдын улс төрийн чөлөөт байдлыг арай ч бүрэн үгүй болгочихоогүй ч ихээхэн хэмжээгээр хязгаарласан байхад харин Манжийн хааны хайр ивээлийг байнга хүртдэг шарын шашныхан "Гадаад мужийг засах яам"-наас гаргасан төрийн хууль цаазаас гадуур үйл ажиллагаагаа явуулж буйд Манжийн хааны ордныхон арга хэмжээ авах шаардлагатай болсныг ойлгож байлаа. Энэ нь Манжийн Эзэн хааны итгэлийг маш ихээр хөсөрдүүлсэн хэрэг болжээ. Монголын Амарсанаа, Чингүнжав нар зэвсэгт бослого /1755-1757/ гаргах үед Жавзандамба ил далд их бага ямар нэгэн хэмжээгээр тэдэнд талтай байгаа тухай мэдээг Бээжин авмагцаа Жавзандамбын хойт дүрийг тодруулахад Бээжин оролцож байх, ингэснээр урьдчилан сэргийлэх шаардлагатайг Манжийн Эзэн хаан ойлгожээ. Тэрээр их цэргээ хөдөлгөж зэвсэгт бослогыг нухчин дарсан 1757 онд 2-р Жавзандамба таалал төгсчээ.

### **Жавзандамбын Төвдөөс тодорсон хувилгаан дүрүүд**

Жавзандамбын хойт дүрийг эдүгээгээс эхлэн зөвхөн Төвдөөс тодруулна хэмээн Манжийн хаан зарлиг гаргажээ. Энэ нь Халх Монголын шарын шашны тэргүүн болон алтан урагийн хаадын хооронд хувь хүмүүсийн харьцаа тогтох явдлыг таслан зогсоох гэсэн манж нарын далд санааг тодоос тод харуулж байв.

Төвдийн түшмэл Данзангомбо болон түүний хятад эхнэрээс мэндэлсэн хүүг 1758 онд Жавзандамбын хувилгаанаар тодруулж Ишдамбийням /Лувсандамбийням/ гэдэг сахилын нэр хайрласан бөгөөд 1763 онд л түүнийг Их Хүрээнээ Богдын сэнтийд залжээ. Түүнийг сэнтийд залахын урьдаар Манжийн эзэн хаан Жавзандамбын улс төрийн хэрэгт оролцох боломжийг хамгийн бага хэмжээнд хүртэл хязгаарлахад чиглэгдсэн арга хэмжээг авсан байлаа. Жавзандамбын эзэмшлийн газар нутгийг 1758 онд Их Хүрээний амбанд мөн захируулах болсон. 1761 онд Хүрээнд манж амбан сууж, төрийн өдөр тутмын бүх л хэргийг захирах болжээ. Баттай эх сурвалжаас үзэхэд "Зарлигаар томилогдон Их Хүрээнээ сууж хэргийг шийтгэх" дээрхи хоёр амбан сайд Жавзандамбын баруун зүүн гар нь болж түүнд "тусалж" байх шийдвэрийг Манжийн эзэн хаан гаргажээ. Ингэснээр Жавзандамбын төрийн хэрэгт оролцох боломж үгүй болж зөвхөн шашны хэргээ л эрхлэх болсныг хянаж чадах болжээ.

Эдүгээгээс эхлэн зөвхөн Төвдөөс хувилгааныг тодруулна гэсэн Манжийн эзэн хааны зарлигийг Монголын язгууртан ноёд тун таагүй хүлээн авсан тул Манжийн эзэн хаан тэднийг тайтгаруулах зохих арга хэмжээг авах хэрэгтэй байлаа. Тэрээр 1764 онд Жавзандамбын Их

<sup>4</sup> Монастырь "Эрдэнэ Зуу", Уланбатор?

<sup>5</sup> Түүний намтрыг V. Veit-ийн нэгэн маш сайн бүтээлээс үзэж болно. V. Veit, *Die vier Qane von Qalqa, Teil II: Biographien*, Asiatische Forschungen, Band 111, Wiesbaden 1990, 65-р тал.

Шавийг улсад гувчуур төлөх алба, хилийн болон өртөө улааны зэрэг гол үндсэн албанаас чөлөөлсөн. Уг арга хэмжээ ямар нөлөө үзүүлэв гэдэг талаар өнөөг хүртэл нэг ч шинжлэх ухааны судалгаа хийгдээгүй байна, гэвч Жавзандамбын мэдэлд байх сүм хийдийн гэх мэт эд хөрөнгө маш ихээр арвижсан нь Манжийн хааны энэхүү зарлигаас үүдэлтэй юм.

Шашнаар дамжуулж монгол үндэстнийг нэгтгэх боломж хамгийн доод цэгтээ хүртэл буурсан. Төвдөөс тодорсон Жавзандамба болон түүнийг хүрээлэх ихэд төвдөжсөн том лам нар монголчуудад тулгараад байгаа нарийн төвөгтэй асуудлыг сонирхох ч үгүй байлаа. Тэд нэг талаас монголчуудын хэл, сэтгэхүйд нэвтэрч бараг чадахгүй байсан, нөгөө талаас эдгээр “шарын шашны бодь сэтгэлтэн” нарын улс төрийн сонирхол нэг улс үндэстний хил хязгаараас хэдийнээ халин гарсан байв. Төвдөөс тодорсон Жавзандамба болон төвдөжсөн дээд лам нар, нөгөө талаас олон монгол энгийн лам нарын хоорондох зөрчил хэрхэн яаж бий болов гэдэг асуудал миний бодоход шинжлэх ухааны судалгааны нэг чухал сэдэв байж болзошгүй юм.

Үүнээс дараа дараагийн Жавзандамбыг монголчууд ихэд сүсэглэн шүтэж байсан гэдэг нь эргэлзээтэй. Төвдөөс тодорсон хувилгаад наад зах нь тун богино насалсныг Позднеев харуулсан байна. 3-р Жавзандамба арван зургаахан насласан бол 5-р Жавзандамба хорин долоо, 6-р Жавзандамба зургаа, 7-р Жавзандамба арван есний сүүдэр дээрээ таалал төгсчээ.<sup>6</sup> Манжийн хааны ордныхон ч гэсэн тэдгээр Жавзандамбад зайлшгүй хүндэтг элийг л үзүүлэх төдийхнөөр хязгаарлаж байжээ. Төвд эсвэл Бээжин орох зөвшөөрөл хүссэн бичигт /тухайлбал 5-р Жавзандамбын/ удаа дараа татгалзсан хариу өгч байжээ.

### Халх Монголын Жавзандамба нарын нэрсийн жагсаалт<sup>7</sup>

	Он сар өдөр	Нэрс
1-р Жавзандамба	1635-1723	Өндөр Гэгээн Занабазар
2-р Жавзандамба	1724-1757	Лувсандамбийдонме
3-р Жавзандамба	1758-1773	Лувсанишдамбийням
4-р Жавзандамба	1775-1813	Лувсантүвдэнванчиг
5-р Жавзандамба	1815-1841	Лувсанчүлтэмжигмэддамбийжалцан
6-р Жавзандамба	1842-1848	Лувсанбалдандамбийжалцан
7-р Жавзандамба	1849-1868	Жавзаннаваанчойживанчигпринлэйжамц
8-р Жавзандамба	1870-1924	Агваанлуvsанчойжинямданзанванчиг

Удалгүй хэдэн жилийн дараа Манжийн хаан хутагт, хувилгаадыг тодруулах шинэ журмыг зохих хууль зүйлийн бичигт тусган оруулсан. Манжийн Тэнгэрийн тэтгэсэн /Qianlong/ хаан 1793 онд Төвдийн бүх том лам нарын /Далай лам, Банчин Эрдэнэ нарыг оролцуулаад/ хойт дүрийг Лхасын хятад амбангийн хяналтан дор шавга татаж тодруулна хэмээн зарлиглажээ. Үүнтэй ижил төстэй утга бүхий зарлигийг Манжийн хаан тухайн онд мөн монголчуудад буулгасан. Монголын шарын шашны бүх хувилгаадыг зөвхөн Бээжин дэх “Гадаад мужийг засах яам” бүртгэн батламжлах болжээ. Жавзандамбын удаахь хувилгаан дүрийг Төвдөөс тодруулж байх талаар хааны зарлигт тодорхой заажээ. 1815 онд гаргасан “Зарлигаар тогтоосон гадаад мужийг засах яамны хууль зүйлийн бичиг”/манжаар: *hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe*/-т багтах “Лам нарын хууль”-ийн 58-р дэвтэрт: “Монгол Фанзегийн аймгаас хутагт ихээхэн ламын хувилгаан дэлгэрэв хэмээн өргөн мэдүүлвээс сул тайж эс бөгөөд албат ард /манжаар: *albatu urse*/ жич Тангудын харц хүмүүний хөвгүүдийн дотроос заалгуул. Далай лам, Банчин Эрдэнийн төрөл ураг, жич олон монгол хан, ван, бэйл, бэйс, гүн, засаг тайж нарын хөвгүүд ач нарын дотроос хувилгаан заахуйг нийтээр цаазлагтун”<sup>8</sup> хэмээн заасан байдаг. Жавзандамба бээр Далай лам, Банчин Эрдэнэ нартай эн сацуу бөгөөд Манжийн хааны ордонд

<sup>6</sup> А. М. Позднеев, *Ургинские кутукту*, Санкт Петербург 1880.

<sup>7</sup> Ш. Чоймаа ба бусад зохиогчид, *Буддын шашин, соёлын тайлбар толь, Буддын цуврал I, II*, Улаанбаатар 1999, 435-436-р тал, мөн Билгийн зулаас Монголын есөн Богдын тухай үзнэ үү.

<sup>8</sup> *Hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe, susai jakūci debtelin, lamasai kooli, hūbilgan-be jorire toktobuha kooli* (манж хэлээр)

эдгээр шарын шашны мяндагтан лам нарыг хүлээн авах ёслол хоорондоо төдий л их ялгарахгүй байх тухай "Лам нарын хууль"-д тогтоон өгчээ.<sup>9</sup>

## 8-р Жавзандамба

8-р Жавзандамба Агваанлуvsанчойжинямданзанванчиг<sup>10</sup> нь 1870 онд Төвдийн нэгэн чинээлэг түшмэлийн хүү болон мэндэлжээ. Ийнхүү Жавзандамбын хувилгаан дүрийг Төвдөөс тодруулсан нь монголын хаад, ноёдын дургүйцлийг туйлын ихээр хүргэсэн. Засагт хан Цэрэндэндэв<sup>11</sup> бээр ёслолын ажиллагаанд оролцох урилгын бичгийг Төвдөд хүргэх ёстой байсан ч өвчтэй гэдгээр шалтаглан үлдсэн ажээ. Үүнийхээ төлөө тэрээр Манжийн эзэн хаанаас хатуу донго хүртжээ. Монголын хаад ноёдын бодол санаа маш хүчтэй өөрчлөгдөж байлаа. Хятадыг эсэргүүцсэн үзэл бодол дээд давхаргынханд улам бүр шингэж байв. 1863 онд Монголын ноёд Хэрлэн голын хөвөөнөө Чингис хааны тахил тайлгын сүмийг бариулсан. Монголчууд ийнхүү аугаа их эзэн Чингисээ дурссан нь улс үндсээ тусгаар тогтноулж, туурга тусгаар болгох тухай бодсон хэрэг байлаа.<sup>12</sup> Ийм нөхцөл байдалд Жавзандамба 1875 онд Их Хүрэнээ Богдын сэнтийд залагдав.

8-р Жавзандамба ээж, эгч дүү нарын хамтаар Хүрээнд ирсэн нь Жавзандамбын Төвдөөс тодорсон өмнөх дүүрдээс ялгагдаж байлаа. Түүний дүү Лувсанхайдав нь удалгүй шарын шашны чойжин лам болжээ. Далай лам бээр Ёнзон ламыг Жавзандамбын багш болгон дагалдуулан явуулсан.

Шинэхэн өргөмжлөгдсөн шарын шашны тэргүүн ихээхэн зөрүүд, дуулгаваргүй нэгэн болох нь төдөлгүй танигджээ. Тэрээр архи ууж, авгай хүүхэн эргүүлэхдээ тун дуртай төдийгүй Манжийн хааны ордноос гаргасан хууль журмыг хүлээн зөвшөөрөхгүй байж ч бараг чадахаар байлаа. Тэрээр Их Хүрэнээс гарахын урьдаар Хүрэн дэх амбанаас тусгай зөвшөөрөл авах ёстой байв. Тухайлбал тэрээр 1887 онд Эрдэнэ Зуу хийд, 1889 онд Амарбаясгалант хийдэд очихдоо тусгай зөвшөөрлийг авсан байна. Гэвч 8-р Жавзандамба энэ журмыг цаашид дагая гэж бодсонгүй. 1890 онд тэрээр зөвшөөрөлгүйгээр хоёр ч удаа Амарбаясгалант хийд рүү явсан байна. Оросын консул Шишмарев Оросын анхны консулын газрыг 1872 онд Гадаад Монголд нээсэн бөгөөд Жавзандамбыг Манж-Хятадын өндөр тушаалтан ноёдтой сергүүлэхийн тулд тэрээр ухаалаг маш нарийн тооцоотойгоор турхирч байсныг дурдалгүй орхиж болохгүй. Гадаад Монголд Орос хэдийнээс илтэд тусгай сонирхолтой байсан бөгөөд монголын хаад ноёд манжийн засаг захиргаанд хүлэгдсэн байх тул тэднийг бодвол Жавзандамба арай онцгой байр суурьтай төдийгүй түүний нөлөөний хүрээ нь улс даяар тархсан байх тул Оросын тал Жавзандамбыг өөртөө татахаас өөр яах билээ. Оросын консулын газрын ажилтнууд дараа дараагийн үйл явдал зөвлөх, залах үүргийг их л болгоомжлонгүй гүйцэтгэж байсан шиг санагддаг бөгөөд энэ нь тэдний хувьд магадгүй тийм ч хэцүү бус байсан байх. Монголчуудаар улсын алба гувчуурыг эрүүдэн төлүүлэх нь нэмэгдсэн, нөгөө талаар Монголыг хятадчилах ажлыг төвөөс удирдан эрчимтэй явуулах болсон нь Монголын ихэс ноёд, дээд лам нарын Манж-Хятадын эсрэг тэрсэлдэн тэмцэх явдлыг улам дэвэргэж өгсөн. 1911 онд Хятадад хувьсгал ялахтай зэрэгцэн Монголын ихэс ноёд, дээд лам нарын Манж-Хятадын эсрэг тэмцэх явдал дээд цэгтээ хүрсэн байв. Гадаад Монголын ихэс ноёд 8-р Жавзандамбад Богд Хаан /Гэгээн/ хэмээх цол өргөж, Монголын хаанаар өргөмжилсөн. Жавзандамбыг Монголын хаанд өргөмжилсөн нь зайлшгүй алхам байсан, учир нь тэрээр халх монголчуудын дунд ямар ч эргэлзээгүйгээр улс төрийн хамгийн чухал нэр хүндтэй зүтгэлтэн байсан төдийгүй мөн Халхын шарын шашны

<sup>9</sup> Гадаад мужийг засах яам (манж аар: *tuleri golo-be dasara jurgan* буюу хятадаар: *li-fan-yuan*)-наас 1815 оны "гадаад муж"-ийн ард түмэнд зориулан гаргасан журам нь ноёлон захирах ухаалаг бодлого байв уу?, *Acta Mongolica*, Volume 1(182), Улаанбаатар 2000, 139-150-р тал.

<sup>10</sup> Х. Жамсран, Шашин төрийг хослон баригч Богд Жавзандамба Хутагт Хаан, *Монголчуудын сэргэн мандалтын эхэн*, Улаанбаатар 1992, 158-184-р тал; С. Идшинноров, Г. Цэрэндорж, *Жавзандамба Агваанлуvsанчойжинямданзанванчигбалсамбуу*, Үнэн, 16.06.1990.

<sup>11</sup> *Li-fan-yuan* (Гадаад мужийг засах яам)-наас хөтөлдөг байсан Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастирийн үндсэн дээр Богд гэгээний засгийн газрын Дотоод Яамнаас 1918-1919 онд гаргасан "Монгол Улсын шастир"-т дурдсанчлан Манжийн Эзэн Хаанаас хишиг болгон Засагт Ханд хайрласан шар өнгийн хантаазыг энэ хэргийнх нь төлөө түүнээс хураан авсан гэжээ. *Монгол Улсын шастир*, I, Улаанбаатар 1997, 105-р тал.

<sup>12</sup> U. B. Barkmann, *Bemerkungen zum mongolischen Nationalismus – ein Versuch* I, *Humboldt-Journal zur Friedensforschung* 3(1992), 1(1993), 80-91-р тал.

тэргүүн болох түүний нөлөө Буриад, Өвөр Монголд тархсан байлаа. Үүнээс гадна түүнийг хаан ширээнд суулгах өөр нэг чухал үндэслэл байсан нь 1-р Жавзандамба болох Өндөр Гэгээн Занабазар нь Түшээт Ханы хүү байсны учир Чингисийн алтан ураг болох бөгөөд харин одоогийн Богд Гэгээн нь Жавзандамбын хувилгаан дүүдээр дамжин түүнтэй нэгэнт холбогдох болсон явдал юм. Иймд Богд Гэгээнийг хаанд өргөмжилснөөр Чингисийн алтан урагт төрийн алтан жолоо дахин шилжлээ гэсэн үг юм.<sup>13</sup>

Богд Гэгээнтэй холбогдох бэлэг тэмдэг мөн үргэлжилсээр байлаа. Богд хааныг "Монгол улсын эзэн, шашин төрийг хослон баригч Богд Хаан"<sup>14</sup> хэмээн алдаршуулах болсон. "Шашин төрийг хослон баригч..." гэдэг өргөмжлөл нь Хятадыг эзлэн оршсон Монголын Юань гүрнийг үүсгэн байгуулагч, Монголын их хаан Хубилай /төр барьсан хугацаа:1260-1294/ Пагва ламыг "Улсын их багш"-аар залж улсыг удирдаж байсныг монголчуудын хувьд санагдуулдаг.

Шарын шашинтан нарын үзэж буйгаар Богд хааныг хаан ширээнээ залсан нь шарын шашны ялалт амжилт байсан бөгөөд мөн тэдний бодлоор энэ нь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нэгтгэн зохион байгуулагч хүчин болсон юм. Улаанбаатар дахь Гандан хийдийн хамба Чойжамц энэ тухайд: "Үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэл хөдөлгөөн нийгмийн бүх анги давхаргыг хамран өрнөсөн 20-р зууны эхэн үеийн түүхэн тодорхой нөхцөлд шашин шүтлэг нь нийт үндэстний хүсэл эрмэлзлэл хүч чадлыг нэгтгэх хүчин зүйл болжээ. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь юуны урьд шашнаа мандуулж, үндэстний улс төрийг сэргээн босгох уриан дор өрнөсөн бөгөөд түүнийг толгойлогч бэлэг тэмдэг нь Богд гэгээн болж, Монголын ард түмний 1910-1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд шашин төрийг хослон барих олноо өргөгдсөн Богд хаант төр тогтжээ."<sup>15</sup> гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Оросын өмгөөлөл дор оршин байсан Монголын хаант улсын хувь заяа эгзэгтэй хэвээр байлаа. Оросод хувьсгал гарч, үймээн самуунд автсны хойно хятадууд энэ сиймхийг ашиглан 1919 оны 11-р сарын 17-нд Монголын засгийн газрын гишүүдийг Монголын тусгаар тогтнолыг Хятадад шилжүүлэх тухай бичигт гарыг үсэг зурахыг албадан тулгасан.

Барон фон Унгерн-Штернбергийн цагаантны цэргүүд Монголд бөөн бөөнөөрөө дайжин орж ирээд 1921 онд хятадуудыг Хиагт хүртэл үлдэн хөөжээ. Унгерн-Штернберг 1921 оны 2-р сарын 26-нд Богд Гэгээнийг Монголын хаан ширээнд дахин залсан байна. Оросын большевикуудын эсрэг тэмцэхдээ Гадаад Монголыг түшиц газар, бэхлэлт болгон ашиглахаар Унгерн-Штернберг тооцоолж байлаа. Зөвлөлтийнхөн хариу арга хэмжээ болгон Унгерн Штернбергийг барьж устгахаар шийдсэн. 1921 оны 8-р сарын 22-нд түүнийг барьсан бөгөөд түүний цэргүүдийг Зөвлөлт Оросын болон Монголын цэрэг бүрмөсөн устгасан. Ингээд Зөвлөлтийн нөлөөн дор орших монголын "Ардын түр засгийн газар" засгийн эрхийг барих болжээ. Нийслэл хүрээг чөлөөлсний дараагаар 1921 оны 7-р сарын 11-нд Богд Гэгээнийг Монголын хаан ширээнээ дахин залсан. Энэ нь үндэсний тусгаар тогтнолын бэлэг тэмдэг Богд Гэгээнд оршиж байдаг хэмээн ойлгох монголчуудын итгэл үнэмшилд нэг талаас нийцэж байсан ч энэ нь бас нөгөө талаар Гадаад Монголыг БНХАУ-ын салшгүй нэг хэсэг хэмээн үзэж буйгаа Хятадын төвийн Засгийн газарт удаа дараа илэрхийлж байсан Зөвлөлтийн гадаад бодлогын далд төлөвлөгөөтэй тохирч байв. 1921 оны 11-р сарын 1-нд "Ардын засгийн газар" Богд Гэгээнтэй "Тангаргийн гэрээ" байгуулж, уг гэрээний ёсоор "хэмжээлшгүй эрхт хаан"-ы улс төрийн бүх эрх мэдлийг хүчингүй болгосон. Үүнд: "Нэгдүгээр зүйл: Монгол улсын Богд хаан Жавзандамба хутагт, шарын шашны богд эзэн болох тул улс төрийн хэрэгт холбогдолгүй, шашны бүх хэргийг хязгааргүй эрхэлбэл зохино."<sup>16</sup> гэж заасан байдаг. Үүнээс хэдхэн сарын дараа буюу 1922 оны 4-р сарын 14-нд Жавзандамбын багш бөгөөд дээд лам нарын шилдэг төлөөлөгч болох Ёнзон хамбын бүх л тусгай эрх ямбыг Ардын засгийн газар хүчингүй болгосон нь ардын засгийн газрын цаашдын бодлогын нэг чиглэл гэж ойлгогдож байв. 1924 оны 5-р сарын

<sup>13</sup> U. В. Barkmann, *Geschichte der Mongolei*, Bonn 1999, 97-р тал.

<sup>14</sup> Но. 66, Богд Жавзандамба Монгол Улсын хаанаар өргөмжлөгдөөд буулгасан зарлигаас, *Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, Баримт бичгийн эмхтгэл* (1900-1914), Улаанбаатар 1982, 126-р тал.

<sup>15</sup> Д. Чойжамц, *Монголын бурхан шашны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд*, Төр, сүм хийдийн харилцаа: Орчин үе, Улаанбаатар 1998, 23-р тал.

<sup>16</sup> *Ардын засгийн газар ба Богд хоёрын хооронд байгуулсан тангаргийн гэрээ*, БНМАУ-ын үндсэн хууль, түүнд холбогдох зарим актыг эмхтгэл, Улаанбаатар 1972, 39-р тал.

20-нд Богд Гэгээн таалал төгссөн нь Зөвлөлтийн ээлжит далд явууллага байсан болов уу гэсэн сэжгийг төрүүлж байна. ЗСБНХУ ба БНХАУ-ын төлөөлөгчид 1924 оны 5-р сарын 31-нд хоёр улсын хоорондын "асуудлыг шийдэх ерөнхий зарчмын тухай хэлэлцээр"-т гарын үсэг зурж, уг хэлэлцээрт Зөвлөлтийн засгийн газар Гадаад Монголыг "БНХАУ-ын нэг хэсэг" гэдгийг дахин хүлээн зөвшөөрчээ. Үүнээс нэг хоногийн хойно буюу 1924 оны 6-р сарын 1-нд Зөвлөлтийн засгийн газрын Нийслэл Хүрээн дэх дипломат төлөөлөгч "БНМАУ"-ыг тунхаглан зарлахыг монголчуудад зөвлөж байжээ. Энэ нь Богд Гэгээнийг таалал төгссөний дараагаар бий болсон шинэ нөхцөл байдалтай холбоотой байв.

Богд Гэгээнийг таалал төгссөнөөс хойш 21 хоногийн хугацаанд улс даяар гашуудал зарлах үеэр тусгай мэргэшсэн оточ лам нар Богд Гэгээний лагшинг давсаар занданшуулж хатаагаад, хуудсан алт, мөнгө сэлтээр чимэн шууж, Гандан хийдэд залжээ. Гандан хийд бол Амарбаясгалант хийд /1., 4-р Жавзандамба/, Дамбадаржаа хийд /2., 3., 6-р Жавзандамба/-ийн нэгэн адил Жавзандамбын шарилыг залсан цөөн хэдхэн газрын нэг нь юм. Энд мөн 5, 7-р Жавзандамбыг нутаглуулжээ.

Богд Гэгээнийг таалал төгссөний дараа Нийслэл Хүрээн дэх дээд лам нар Жавзандамбын хувилгаан дүрийг тодруулах ажлыг бэлтгэж эхэлсэн. Жавзандамба монгол хүний дүрд хувилж тодорно гэдэгт дээд лам нар санал нэгдсэн. Энэ явдлыг мөн нэлээд яаравчилж байв. Жавзандамбыг дахин тодруулах нь чухал биш гэдгийг Коминтерний зөвлөгч нар тэдэнд сануулж байлаа. БНМАУ байгуулагдсаныг зарлан тунхаглаж, төр шашны хэрэг тусдаа байхаар үндсэн хуулиндаа заасан нь засгийн газрын бодлогын чиглэл өөрчлөгдсөнийг тодорхой илтгэж байна.<sup>17</sup> Шинэ хууль тогтоомжийн дагуу лам нар Улсын Их Хуралд сонгох сонгогдох эрхгүй<sup>18</sup> өөрөөр хэлбэл улс төрийн хувьд ямар ч эрхгүй болжээ. 1925 оны 4-р сарын 3-нд засгийн газар Их Шавийн засаг захиргааны бүтцийг хүчингүй болгож, бие даасан аймгийг байгуулсан. Мөн төдөлгүй Монгол Ардын Хувьсгалт Нам /МАХН/-ын 4-р Их Хурлаас Богд Гэгээний хөрөнгийг хурааж улсын мэдэлд шилжүүлэх шийдвэрийг гаргасан.<sup>19</sup> Ийнхүү Монголын шарын шашны хамгийн том эрх мэдэлтэн болох Богд Гэгээний хөрөнгийн үүсвэрийг үгүй болгосон. 1924 оны статистикийн мэдгээгээр Монголын бүх малын 20 орчим хувь буюу 2.912.520 толгой мал сүм хийдийн мэдэлд байсан бөгөөд Жавзандамбын Их Шавийн /1912 оны дараа<sup>20</sup> 89.362 шавь ардтай байсан/ данстай 609.000 орчим толгой мал, Нийслэл Хүрээний хийдүүдийн мэдэлд 293.000 орчим толгой мал тоологдсоноос үзэхэд Жавзандамба 902.000 толгой малыг толгой мэдэн зарах эрхтэй байсан нь түүнийг эдийн засгийн хувьд нөлөөгүй этгээд байгаагүйг гэрчилж байна.<sup>21</sup>

Богд-Хан Уулын аймгийн /одоогийн Сэлэнгэ аймгийн Зүүнхараа сум/ Ноён-Уул хошууны Ялбаг хэмээх газар ээжтэйгээ амьдрах Түдэвийн Лувсандорж гэдэг хүүг Жавзандамбын хувилгаан хэмээн лам нар тодорхойлжээ. Ардууд түүний ээжийг далдыг хардаг гэхийн сацуу "Хараагийн мэргэн хүүхэн"<sup>22</sup> хэмээдэг байжээ. Хүүг Жавзандамбын хойт дүр болохыг Далай лам, Банчин Эрдэнэ нараар аль болох түргэн батламжлуулах хэрэгтэй байсан. Үүнд удалгүй нэг сайхан завшаан тохиожээ. 1926 оны эхээр Монгол Ардын Засгийн газар гүн Л. Гомбо-Идшинг Лхас /Төвдийн/ хотноо суух элчингээр томилсон. 1926 оны 9-р сарын эхээр түүнийг Төвд үрүү явах үед<sup>23</sup> Монгол Ардын засгийн газрын зөвшөөрлөөр Гэндэнсоном, Жанчивринчен нар дагалдан явжээ. 1926 оны 9-р сард Японы улс төрийн хүрээнийхэн "Азийн орнуудын ард түмнийг нэгтгэе", "Большевикзмын эсрэг тэмцье" уриан дор Нагасаки хотноо Өвөр Монголын ноёд, лам нарын бага хурлыг зохион байгуулсан. Энэ бага хуралд Банчин лам ч гэсэн оролцсон байна.<sup>24</sup> Монголын лам нарын дотор "Ардын хувьсгалын ололт амжилтанд аюул учруулахуйц"

<sup>17</sup> Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн Хууль, БНМАУ-ын үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхтгэл, Улаанбаатар 1972, 120-р тал.

<sup>18</sup> Мөн тэнд, 158 тал.

<sup>19</sup> Мөн тэнд, 190 тал.

<sup>20</sup> Х. Жамсран, *Шашин төрийг хослон баригч Богд Жавзандамба Хутагт Хаан*, Монголчуудын сэргэн мандалтын эхэн, Улаанбаатар 1992, 164-р тал

<sup>21</sup> Д. Батаа, *Шашин, түүнийг Монголд зохицуулсан нь* (1924-1997), Улаанбаатар 1998, 37-р тал.

<sup>22</sup> *Есдүгээр Богдыг Монголоос тодруулж байжээ*, Өдрийн Сонин, 09.09.1999.

<sup>23</sup> Төлөөлөгчдийн хэрхэн явсан тухайг Төвдөд суугаа БНМАУ-ын элчин сайдын яамны нарийн бичгийн даргын дурсамжаас үзнэ үү: И. Амгалан, *Цастын орныг зориод цайдмын Монголд саатсан нь*, Улаанбаатар 1991.

<sup>24</sup> Ц. Батбаяр, *Монгол ба Япон XX зууны эхэн хагаст*, Улаанбаатар 1998, 57-р тал.

“хувьсгалын эсрэг хүчин” нуугдаж буйг Москва ойлгомогцоо ихэд түгшиж байлаа. 1926 оны 9-р сарын 16-нд хуралдсан МАХН-ын 5-р Их Хуралд Коминтерний Гүйцэтгэх Хорооны Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газраас илгээсэн баярын бичигт: “Энэ тухайд лам нар нь хамгаас илүү хортой мэт бөгөөд бөгөөд одоо ч гэсэн Богд Гэгээнийг дахин буй болгох зэргээр оролдож буй ажгуу.”<sup>25</sup> гэж онцлон заажээ. Намын тус Их Хурал дээр Зөвлөлтийн зөвлөх нарын шахалт дарамтын дор ерөнхий сайд Цэрэндорж өөрийн хүсэл зоригоос гадуур *ex officio* буюу нэгэн мэдэгдэл хийсэн нь Богдын хойд дүр хэмээн тодруулааад байгаа хүүгийн аав сурвалжит язгууртан байсан бөгөөд /тухайн үед язгууртан сурвалжит гаралтай байх нь бараг үхлийн ялтай нүгэл мэт тооцогддог байсан/ хүүгийн ээж нь Ардын засгийн газрыг дайрч давшлан, Банчин Эрдэнэ 80.000 цэргээ дагуулан дайлахаар ирж явна хэмээн ярьсан гэжээ.<sup>26</sup> Улсын 3-р Их Хурлын шийдвэрт “Богд Жавзандамба хутагтын дараагийн есдүгээр дүрийг залах явдал үгүй боловч үүнээс хойш залах түүх байхгүй гэж учир хэрхэн болгохыг Далай ламд айлтгаж явуулсан нь зүйтэй болжээ.” гэж заажээ.<sup>27</sup>

Л. Гомбо-Идшин тэргүүтэй төлөөлөгчидтэй Лхас хотноо Далай лам, Банчин Эрдэнэ нарт бараалхаж, Жавзандамбын хойт дүрийг батламжилж өгөхийг хүссэн. Энэ хүсэлтийн учир төвд хэлээр бичсэн албан бичиг захидлыг 15 лангийн мөнгөн өмбүүн хамт Банчин Эрдэнэд өргөн барьжээ. Ингээд Банчин Эрдэнэ хүүг Жавзандамбын хойт дүр мөн гэдгийг батламжилсан тамга тэмдэг бүхий албан бичиг гардуулсан ажээ. Гомбо-Идшин Монголд эргэн ирээд 1927 онд уг тамга бүхий албан бичгийг 8-р Жавзандамбын багш асан Ёнзон Хамба ламд өргөвэй. Тэрээр үүнийг цааш нь Ардын засгийн газарт барьжээ. Зөвлөлтийн зөвлөх нар шахалт үзүүлсний улмаас Ардын засгийн газар 9-р Жавзандамбыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзав. 1928 онд Гэндэнсоном, Балдан, Найдансүрэн зэрэг лам нар нөхцөл байдлыг нааштайгаар эргүүлэхээр дахин дахин оролдсон боловч бүтэлгүйтсээр байлаа. Үндэсний ардчилсан үзлийг тууштай баримтлагч ерөнхий сайд Б. Цэрэндорж 1928 оны 2-р сарын 13-нд нас барснаар зөвлөлтийн зөвлөх нарт Монголын дотоод бодлогод гүн гүнзгий нэвтрэн орж, нөлөөлөх өргөн дэлгэр боломж цэлийтэл нээгдсэн ажээ. Дотоодыг хамгаалах газар 1928 онд тэдээр лам нарыг баривчлан гурван жилийн хугацаанд шоронд хорьжээ.

1930 оны 9-р сарын 28-нд БНМАУ-ын Дээд Шүүх Гомбо-Идшинг “хувьсгалын эсрэг гэмт хэрэгт оролцсон” гэдэг хэргээр цаазаар авах ял оноож, ялыг гүйцэтгэсэн байна.<sup>28</sup>

Жавзандамбын хувилгаан хэмээн “тодорхойлогдсон” Т. Лувсандорж Сэлэнгэ аймагт мал маллан амар тайван шиг амьдарч байгаад 1948 онд насан нөгчжээ. Уламжлалт шарын шашинтай байсан орчинд өсөж хүмүүжсэн Монголын “коммунистууд” Жавзандамбын хувилгаан дүрд муу зүйл хийхээс айж байсан эсэхийг хичнээн судлавч мэдэх аргагүй юм.

Бидэнд мэдэгдэж байгаа баримтуудад түшиглэн дүгнэж хэлбэл 1929 оны 2-р сарын 15-нд л Засгийн газар албан ёсоор эцсийн шийдвэрийг гаргаж, Богд Гэгээн зэрэг хутагт хувилгаадын хойт дүрийг энэ өдрөөс эхлэн цаашид хүлээн зөвшөөрөхгүй болохыг мэдэгдсэн байна.<sup>29</sup> Энэ мэт хууль бүгд хүчингүй болсон гэх боловч хутагт, хувилгаадын тухайд л хүчинтэй байгаа юм шигээр өнөөгийн төр засаг хандаж байгаа нь хачирхал төрүүлдэг.

30-аад он гэхэд Монголд шарын шашин бараг устгагдсан байв. Шарын шашны хувьд сталинч аллага гол арга хэрэгсэл нь болж байлаа. Дотоодыг хамгаалах газрын Зөвлөлтийн зааварлагч М. Ф. Чибисов Монголын бүх сүм хийдүүдийн байрлах газрыг нарийвчлалтайгаар тэмдэглэсэн газрын зургийг үйлджээ. 1937 онд Монголын 750 гаруй сүм хийдийг төлөвлөгөөний дагуу шат дарааллан устгасан бөгөөд үүнд зөвлөлтийн НКВД-ийн болон Монголын тусгай

<sup>25</sup> КИГХ ба КИГХ-ны дорнодын нарийн бичгийн дарга нарын газраас МАХН-ын 5-р Их Хуралд илгээсэн баярын бичиг, Коминтерн ба Монгол, Улаанбаатар 1996, 129-р тал.

<sup>26</sup> Монгол Ардын Хувьсгалт Намын 5-р Их Хурал, Улаанбаатар 1987, 17-р тал.

<sup>27</sup> Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газар, Засгийн газар болон олон яамдын тайлангийн тухай Улсын 3-р Хурлын шийдвэр (01.-13.11.1926), БНМАУ-ын Үндсэн Хууль, түүнд холбогдох зарим актын эмхтгэл, Улаанбаатар 1972, 210-р тал.

<sup>28</sup> Д. Гомбосүрэн, Хичээнгүй баатар гүн Л. Гомбо-Идшин (1862-1939), Үнэн, 19.08.1990.

<sup>29</sup> Богд ба хутагт Хувилгаадыг дахин бий болгохыг зогсоосон тухай..., БНМАУ-ын Үндсэн Хууль, түүнд холбогдох зарим актын эмхтгэл, Улаанбаатар 1972, 220 тал.



ангиуд оролцсон байна. Үүнд хичнээн лам хэлмэгдсэнийг нарийн хэлэхэд төвөгтэй. МАХН-ын хуучин мэдээгээр 1937 оны хэлмэгдлээс өмнө Монгол 80.000 ламтай байжээ.

Дашзэвэг ламын хуучилснаар 1937/1938 онд Зөвлөлтийнхөн Гандан хийдийн дэргэдэх гурван ноёон сүм дуганг эвдлэн сүйтгэсэн бөгөөд уг сүм дуганууд дотор 5, 7, 8-р Жавзандамбын занданшуулсан шарилыг шуумал дүрээр нандигнан хадгалж байжээ. Шуумал дүрийг задлах үед дотроос нь занданшуулсан шарилууд гарч ирсэн. Уг үйл ажиллагааг гардан удирдаж явуулсан Зөвлөлтийн офицер энэ тухай Монголын ерөнхий сайд асан Х. Чойбалсанд мэдэгдээд, эдгээр шарилуудыг Баруун Наранд нутаглуулахыг тушаасан гэдэг.<sup>30</sup>

Хутагт хувилгаад нь шарын шашинд маш чухал үүргийг гүйцэтгэдэг билээ. Гадаад Монголын түүхнээ Жавзандамба хутагт нар онцгой байр суурийг эзэлж байсанд хэн ч эргэлзэхгүй биз ээ. Халх Монголд шарын шашин дэлгэрсэн нь Өндөр Гэгээн Занабазарын амьдралтай юутай ч атугай холбогдож байхад харин 2-р болон 8-р Жавзандамба нар шашны хэргийг эрхлэхээс гадна Хятадаас туурга тусгаар үндэсний улсаа байгуулахыг эрмэлзэж байв. 8-р Жавзандамба бээр Богд Хааны ширээнд залагдсаны хойно тамгатай хутагт нарыг батламжлах онцгой эрх ямбыг мөн түүнчлэн эдлэх болжээ. Харин тэр үеийг хүртэл Бээжин дахь Li-fan-yuan буюу Гадаад мужийг засах яам энэ эрхийг ганцхүү өөртөө хадгалсаар ирсэн байна.

Орчин үед Монголын шарын шашны сүм хийдүүд хутагт хувилгаад үгүй бөгөөд олон шавь нар сэлтийг хураасан шашны лидерүүд урьдын адил үгүйлэгдсээр л байна. Ийм ч учраас Далай ламаар батламжлагдчихаад байгаа Жавзандамбын есдүгээр дүр өнөөг хүртэл Энэтхэгт амьдарч буй нь зарим монголчуудад нэгийг бодогдуулах биз ээ.

### **Монголд шарын шашин дэлгэрсэн нь<sup>31</sup>**

Улс төрийн өөрчлөлт гарч, ардчиллын үйл явц эхэлснээр Монголын ард түмний нэлээд хэсэг нь уламжлалт шарын шашнаа дахин сэргээх боломжийг олсон юм. Шашин төр хоёрын хоорондын харилцааг ардчилсан нийгмийн зарчимд нийцсэн байдлаар зохицуулах болсон. Шашин шүтлэгийг чөлөөтэй болгосон нь цаашлаад төрөөс хүндэтгэн үзэх иргэний үндсэн эрхэд хамаарагдах болсон юм.

Улаанбаатар дахь Гандан хийд болон 1991 онд байгуулагдсан Монголын Бурхан шашинтны төв нь шарын шашныг дахин дэлгэрүүлэх үйл явцыг таван үндсэн чиглэлд явуулж байна.

1. Сүм хийдүүдийг сэргээн засварлах буюу дахин шинээр барьж, шашны үйл ажиллагаагаа дахин сэргээсэн.  
Энэ зорилгоор сүм хийдүүдийг соёл түүхийнх нь ач холбогдол болон тухайн нутагт оршин суугаа хүн амын нягтшилийн дагуу гурван категорид хувааж байна.
  - а) Аймгийн төвүүд болон томоохон суурин газруудад байрлах соёл, түүхийн үнэ цэнэ бүхий Эрдэнэ-Зуу, Дамбадаржаа, Амарбаясгалант, Баруун Хүрээ зэрэг сүм хийдүүд (нийт 32 сүм хийд)
  - б) 5000-аас доошгүй хүн амтай суурингийн төвүүдэд байрлах сүм хийдүүд.  
Жишээлбэл: Өлгийн хийд, Баруун Чойр, Балдан Брэйвүн, Онгийн Хүрээ, Уянгын хүрээ, Лу Гүний Хүрээ, Уянга, Тарни, Рашаант, Ховдын Булганы хийд
  - в) Ач холбогдлоор багавтар жижиг сүм, хийдүүд.

<sup>30</sup> Н. Дашзэвэг, *Богд Хааны шарилыг залсан нь*, Ардын Эрх, 09.06.1993.

<sup>31</sup> cf. K. Sagaster, *Religion and Group identity in Present Mongolia*, in *Dissociation and Appropriation Responses to Globalization in Asia and Africa*, Studien 10, Zentrum Moderner Orient, S. 185-193; U. B. Barkmann, *Lamaism in der Mongolei (Teil I)*, Asien, Afrika, Lateinamerika 1994, S. 45-56, *The revival of lamaism in Mongolia*, Central Asian Survey 1(1997), S. 69-80, *Religiöser Pluralismus und nationale Identität in der Mongolei*, KAS-Auslandsnachrichten 2(1998), S. 98-115.

2. Лам нарт зориулж сургалтын тогтолцоог бий болгосон. Социализмын үед үндэслэн байгуулсан Шашны Дээд Сургуулийг "Өндөр Гэгээн Занабазар"-ын нэрэмжит Бурхан шашны их сургууль болгон өөрчилсөн бөгөөд түүнд жил бүр 120 орчим оюутан суралцаж байна. Уг их сургууль нь хөдөө орон нутгийн сүм хийдүүдээс ирсэн лам нарт зориулж хоёр жилийн эрчимт курсыг зохион байгуулан хичээллүүлэх болж, бурхан шашны үндсэн мэдлэг, хурлын дэг жаяг зэргийг зааж сургаж байна. Урьд Гандан хийдийн нэрийг өргөж явсан дацангуудын баялаг уламжлалыг сэргээж, Дашчоймбол дацан, Гунгаачойлон дацан, Ядгаачойлон дацанг тус тус нээн ажиллуулах болсон. Дашчоймбол дацан гэхэд л 100 гаруй шавилан суралцагчидтай. Мөн Улаанбаатар хотноо Бурхан шашны дунд сургууль үүд хаалгаа нээсэн бөгөөд энэ нь шавь сурагчиддаа 60%-ийн ерөнхий боловсрол, 40%-ийн шашны боловсролыг олгодог байна.
3. Сүсэгтэн олны шашны боловсролыг дээшлүүлэх болсон. Нийгмийг шашнаас ангижруулах явц нь олон арван жилийн туршид үргэлжилж, шарын шашны сүсэгтэн нарт ч мөн нөлөөгөө үлдээлгүй хоцорсонгүй. Социализмын үед хурал номын үйл ажиллагаа төрийн хатуу хяналтан дор зөвхөн Улаанбаатарт явагдаж байсан. Шарын шашны ном судрууд бараг үгүй болсон байв. Энэ нь сүсэгтнүүд судар номын утгыг эцэг эхийнхээ хүрээнд зөвхөн амаар уламжлан ухаарна гэсэн үг юм. Бурхан шашны номлолын учир утгыг тодорхой мэдээд ирэхлээр шашны тухай ард түмний бүдэг бадаг ойлголтын түвшинд сүсэг бишрэлийг ойлгон хүлээн авах нь нэлээд багассан. Ийнхүү улс төрийн өөрчлөлтийн дараа бурхан шашны номын утгыг таниулах явдал нь Монголын бурхан шашинтны төвийн эн тэргүүний үүрэг болсон билээ. Дээрх төвөөс бурхан шашны ном судруудыг (Ганжуур, Данжуур) судалж, зохих зарим ном, сэтгүүлүүдийг (жишээлбэл Лавайн эгшиг, Бурхан шашны сэдвээр улирал тутамд гарах сэтгүүл; Билгийн мэлмий, шарын шашны сонирхогч нарт зориулсан сэтгүүл) хэвлүүлэн гаргаж, Гандан хийдийн номын сан хөмрөгийг баяжуулахын хамт радио телевизийн нэвтрүүлгээр байнга сүсэг бишрэлийн асуудлыг хэлэлцүүлж байна.
4. Гандан хийд болон Монголын Бурхан шашинтны төв нь олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж эхэлсэн. Монголын бурхан шашинтнууд Дэлхийн Буддистын холбооны үйл ажиллагаанд оролцохын хамт, Улаанбаатарт төвтэй Азийн буддистуудын энх тайвны бага хурлын ажлыг удирдаж, тухайлбал Азийн Бурхан шашны дээд лам нарын Киотогийн уулзалтанд оролцсон байна. Далай ламын өөрөөр хэлбэл Энэтхэгийн шашны боловсролын байгууллагуудтай (Диалектикийн Их Сургууль, Сэра дацан, Гоман дацан болон Варанашийн Их Сургуульд монгол лам нар суралцаж байна) хамтран ажиллаж байгаа нь онцгой ач холбогдолтой юм.
5. Гандан хийдийн удирдлага нь Монголын бурхан шашинтны төв зэрэг төвлөрсөн бүтэц бий болоход бүр эхнээс нь түлхэц өгсөн билээ. Энэхүү бүтэц бий болоогүй байхад дахин шашныг дэлгэрүүлэх үйл явцын талаар мэдээж бодохын ч хэрэггүй байсан байх болов уу.<sup>32</sup>

Сүүлийн 10 жилийн хугацаанд нийт 2500 ламтай 154 сүм, хийд үйл ажиллагаагаа сэргээн явуулах болсон. Сүм хийдүүдийн хооронд харьцангуй сайн зохион байгуулагдсан янз бүрийн харилцааны сүлжээ бий болж байна. 1996 онд улсын шүтээн Мигжид Жанрайсигийг шүншиглэн залжээ. Шарын шашны уламжлалыг дахин сэргээсэн явдал нь эрт орой хэзээ нэгэн цагт шарын шашны хутагт хувилгаадын тухайлбал мөн 9 дүгээр Богд Жавзандамбын хойд дүрийн тухай асуудлыг зайлшгүй хөндөх болсон. Энэ асуудал улам бүр хурцаар тавигдах болж, Жавзандамба өөрийн 9 дүгээр хувилгаан дүрээрээ тэнд амьдарч буйг Дармасалагаас зарлан мэдэгджээ.

<sup>32</sup> Би энд Хамба лам Чойжамцын дүгнэлтийн хэсгийг баримтлан бичлээ. Д. Чойжамц, *Монголын Бурхан шашны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд*, Төр, сүм хийдийн харилцаа: орчин үе, Улаанбаатар 1998, 18-35 дугаар тал.

## 9 дүгээр Жавзандамба гэж хэн бэ?

Түүний өөрийнх нь хэлснээр Жамбалнамдолын Чойжийжанцан (Соном Даргиа) нь 1932 оны 11 дүгээр сард Лувсанжамбал ламын хүү болон мэндэлсэн бөгөөд түүний гэр бүл нь Төвдийн алдарт мэргэн ухаантан Раллозава (?)-гаас угсаа гэрвалтай гэдэг. Түүний ээж Янжинлхам нь Хамбогийнх. Тэрээр дурсан ярихдаа: "Намайг бага байхад гурван чойжин буулгаж, Есдүгээр Богд Жавзундамбын дүрд тодруулсан байсан. Гэхдээ тухайн үеийн нийгмийн байдлаас шалтгаалж энэ асуудал албан ёсоор яригддаггүй байлаа" гэжээ. Тэрээр хүрээ хийдэд шавилан сууж, Барвингомин дацанд 12 жил суралцаж бурхан шашны зохистой боловсролыг эзэмшсэн ажээ. Тэнд тэрээр анх удаа монгол хүмүүстэй нүүр тулан учирсан бөгөөд түүний анхны багш нар нь халх, буриад хүмүүс байсан ажээ. Тэрээр дацан сургалтынхаа 12 дахь жил буюу сүүлийн жилд Төвдөөс Энэтхэг рүү дүрвэж, 1961 онд нэг жилийн хугацаанд Энэтхэг, Непалийн хооронд орших хилийн бүсэд амьдарч байгаад дараа нь Энэтхэгт амьдрах болжээ. 1986 онд тэрээр Лхас дахь Пунцаглин хийддээ эргэн ирсэн. Энэ үед түүний хуучин Темепек сүм нь үр тарианы агуулах болон хувирч, лам нар нь сураггүй болсон байв. Тэрээр Хятадын албаны төлөөлөгчидтэй уулзаж, хийдээ дахин ашиглалтанд оруулах тухай өөрийн хүсэлтээ илэрхийлсэн. Хийдээ дахин нээх зөвшөөрлийг түүнд албаны хүмүүс олгосон төдийгүй сүмийн үйл ажиллагааг эхлээд 50, дараад нь 300 хүртэл лам нартайгаар явуулахыг зөвшөөрчээ. Сүмийн гол шүтээн болох "100 Будда"-г дахин засварлан сэргээхэд зориулж 70.000 юань, сүмийг ашиглалтанд оруулахад зориулж 200.000 юанийг Хятадын албаны хүмүүс түүнд гардуулж өгсөн. Хожим нь Хятадын эрх барих хүмүүс түүний хийсэн ажилд нь талархаж түүнийг хүлээн авч уулзсан байна. Түүний хоёр дүү нь Төвдөд төрийн байгууллагад ажиллаж байгаа сурагтай. 1992 онд тэрээр дахин Төвдөд айлчилсан. Хятадын албаны хүмүүс бүүр түүнтэй эелдэг найртай хандаж байв. "Харин 1990-иэд оны үеэс Монголын сүсэгтэн олон, сүм хийдийнхний хүсэлтээр, албаны зарим нэг хүмүүсийн асууж лавлаж байсны дагуу 1992 онд Далай багш намайг Энэтхэгийн Дарамасалад Есдүгээр Богдоор ширээнд залсан юм." Тэрээр долоон наснаасаа Далай ламыг таних болсон бөгөөд АНУ, Канад, Оросоор аялан явж байжээ. 1992 оноос хойш тэрээр Монгол Улсад очих оролдлого хийж байлаа. Тэрээр үүнийг тайлбарлан ярихдаа: "Долоон жилийн өмнөөс л Монголд ирэхийг хүсч чармайж байсан. Гэвч зарим нэг шалтгааны улмаас ирж чадаагүй ээ. Сүсэгтэн олон Есдүгээр Богд Энэтхэгт байдаг гэдгийг мэдээд мөргөх юмсан гэж бодож байдаг юм билээ." Энэ бүхэн бол Жамбалнамдол Чойжийжанцангийн өөрийнхөө тухай дүрсэлсэн зүйлс юм.<sup>33</sup>

1995 оны 4 дүгээр сарын 12-нд нэгэн монгол сонинд<sup>34</sup> гарсан өгүүллээр Богдын тухай мэдээллийг баяжуулъя. Үүнд бичсэний дагуу эцэг эх нь хүүгээ балчир байхад нь 13 дугаар Далай ламд шавь оруулсан ажээ. 1933 оны 12 дугаар сарын 17-нд 13 дугаар Далай лам таалал төгссөний хойно Төвдийн нөлөө бүхий лам Цамба Чойдог (монгол бичлэгийн дагуу) хүүг том ламын хувилгаан дүр болохыг тодруулж Соном Даргэ хэмээх нэрийг хайрлажээ. Соном Даргэ 8 дугаар Жавзандамын хувилгаан дүр болохыг Төвдийн захирагч Васгрэнг Ринбүүчий (1933-1939 оны хооронд захирагч байсан) батламжилж, хүүг нууцгай газар аваачихыг Цамба Чойдогт даалгажээ. Ингээд түүнийг хүмүүс Дэцэн Даргэ, хожим нь Жамбал Намжил Чойжи Жалсан (монгол бичлэгийн дагуу) хэмээн нэрлэх болсон. 1956 онд тэрээр анх удаа олны нүдний өмнө гарч Энэтхэгт бурхан шашны томоохон баярт оролцож байсан гэнэ. 1959 онд тэрээр Непалаар дамжиж Энэтхэгт дүрвэн ирсэн. Энэтхэгт тэрээр ламын амьдралаасаа гарч, хоёр эхнэр, дөрвөн хүүхдүүдтэйгээ тарчигхан амьдарч байжээ.

9 дүгээр Жавзандамбыг тодруулсан тухай дам яриа 1947 онд хэдийнээ тархсаныг дээрх өгүүллийн өөр хэсгээс мөн үзэж болно. Чингэхдээ 1926 онд Жавзандамбын 9 дүгээр хувилгаан дүр хэмээн Панчен ламын тодруулсан Т.Лувсандоржийн тухай төдийгүй мөн дээр дурдсан Соном Даргэгийн тухай ярьж байсан хэрэг. Монголын шарын шашны лам нарын дунд нэр алдар нь ихэд түгсэн лам нэрийн нэг болох 5 дугаар Дилав хутагт Жамсранжав 9 дүгээр Богдтой уулзахаар шийдсэн. 9 дүгээр Богдын хувилгаан дүрийг тодруулсан нь зүгээр л нэг хошин жүжиг байсан хэмээн янз бүрийн талууд түүнд ойлгуулсан байв.

<sup>33</sup> IX Богд Жавзандамба: *Би Далай багштай багаасаа багш шавийн барилдлагаатай явж ирсэн*, Өдрийн Сонин, 14.09.1999.

<sup>34</sup> Г. Ганболд, *Есдүгээр Богд гэж хэн бэ?*, Ардын Эрх, 12.04.1995

Дээр дурдсан бодит баримтуудын үндсэн дээр доорхи зүйлсийг тогтоон тодорхойлж байна.

1. Улс төрийн амбиц ихтэй Төвдийн захирагч Васгрэнг Ринбүүчий 1932 онд мэндэлсэн Соном Даргэг 1935 онд Жавзандамбын хойд дүр болохыг тогтоож өгчээ. Энэ нь Далай лам таалал төгсөөд түүнийг залгамжлагч хараахан тодроогүй байсан тэр үед тохиосон юм. Харин тэгэхэд Панчен лам Төвдөөс алс хол байсан. Заншсан ёсоор мод шодож, Далай лам, Панчен-Эрдэнэ хоёроор батламжлуулах явдал тохиосонгүй.
2. 24 гаруй жилийн хугацаанд 9 дүгээр Богд хар хүний амьдралаар амьдарсан бөгөөд сая 1986 онд л ламын амьдралдаа эргэж орсон. Тухайн жил тэрээр хачирхалтайгаар Хятад уруу дахин аялан явсан. Улаанбаатарын Гандан хийдийн хамба лам Чойжамц 1983-1986 онуудад Дармасалад байх үедээ 9 дүгээр Богдтой уулзаж байсан хэмээн дурдсан байдаг.<sup>35</sup>
3. Балчир хүүхэд ахуй насандаа албан ёсоор хувилгаанаар тодорч батламжлагддаг байсан бусад бүх Жавзандамба нартай харьцуулахад түүнийг сая 60 настайд нь л батламжлан өргөмжилжээ.

### 9 дүгээр Богд Жавзандамбыг Монголд урьсан тухай:

#### I үе шат - Далай лам Жавзандамбыг батламжилсан нь

Монголд улс төрийн өөрчлөлт явагдаж буй тусгай нөхцөлүүдийн дунд Жавзандамба амьдарч буй эсэх тухай яриа маргаан дэгдсэн. Өнгөрсөн түүхтэй харьцуулж үзэхэд монголчууд мэдээж баяр жаргалаар бялхаж, энэ нь үр шим багатай, үндсэрхэг үзлийг хөндөж байв. Монголын улс төрийн түүхийг шинээр боловсруулах ажлын хүрээнд нэн тэргүүнд намтар судлал ихээхэн ач холбогдолтой юм. Монголын тусгаар тогтносон улс байгуулагдсан явдлыг өнөөг хүртэл монголчууд Жавзандамбатай холбож үздэг тул түүнд онцгой бэлэгдлийн хүч оршиж байдаг нь ер ойлгомжтой юм. 1990 оны 4 дүгээр сард Монголын Социал Демократ Нам 8 дугаар Жавзандамбын мэндэлсний 120 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотноо бага хурал зохион байгуулсан. Энэтхэгт амьдарч буй Жавзандамба нь 9 дүгээр Богд үнэхээр мөн эсэх талаар маргалдаж байх нь ямар ч ашиггүй атал энэ нь уг бага хурлын үндсэн чиглэл болчихжээ. 10 дугаар Жавзандамбыг Монгол Улсаас өөрөөр хэлбэл монголчуудын дотроос өөрсдөө тодруулах нь чухал юм гэжээ.<sup>36</sup> Энэхүү байдал нь Далай ламд аятайхан бус сэтгэгдэл төрүүлээгүй нь ч бас ойлгомжтой юм. Бусад бүх шашны удирдагчын нэгэн адил Далай лам нь ч мөн адил өөрийн шашны нөлөөг нэмэгдүүлж, бэхжүүлэх амин чухал сонирхолтой. Монголын шарын шашинд хутагт хувилгаад чухал үүргийг үгүй бол шийдвэрлэх үүргийг гүйцэтгэсээр ирсэн билээ. XX зууны 30-аад оноос хойш Монголд хутагт хувилгаад тодроогүй байв. Хэрвээ Монголд шарын шашныг дахин дэлгэрүүлэх үйл явцыг удаан хугацаагаар дэмжиж тэтгэе гэвэл хутагт хувилгаадыг тодруулдаг уламжлалыг шарын шашны зан үйл болгон урьдын адил нэвтрүүлэх ёстой.

Бурханы шашны нэгэн хутагт бөгөөд Далай ламын багш асан Бакула Ринбүүчийг Бүгд Найрамдах Энэтхэг Улс 1990 оны 1 дүгээр сарын 1-нээс Улаанбаатарт элчин сайдаар томилсон нь санамсаргүй явдал биш болов уу. Ингэснээр Бакула багш Монголд сууж байгаа цорын ганц хутагт хувилгаан болсон ажээ. Хүн ардыг нь гэгээрүүлэхийн тулд Бакула умар зүг оддог гэжээ. Түүхэн үүднээс авч үзвэл тэрээр маш их бэлэгдэл бүхий хутагт юм. БНЭУ-ын элчин сайд ч өөрийн Монгол дахь үүргийг ийнхүү ойлгосон мэт санагдсан. Монголын Засгийн газар хүлээцтэй хандсан тул тэрээр маш богино хугацааны дотор шарын шашныг дахин дэлгэрүүлэхэд тэргүүлэх байр суурийг эзэлсэн байв. Тэрээр 1990 онд хэдийнээ 73 нас сүүдрийг зооглож байсан тул

<sup>35</sup> Д.Чойжамц, *Буянтан төрүүлсэн нутаг даа*, Өдрийн Сонин, 25.09.1999.

<sup>36</sup> Б. Билигт, *IX. Богдоо залахгүйгээр Ар Монголд Х. Богдыг хэрхэн тодруулах вэ?*, Ардчилал, 18.03.1995.

түүнийг таалал төгссөний хойно Монголд хойд дүр нь тодрох болов уу гэж цөөнгүй хүмүүс таамаглаж байв.

1991 оны 9 дүгээр сарын 20-нд Далай багш "бусдын хүсэлтийн дагуу" Соном Даргэг 8 дугаар Жавзандамбын хувилгаан дүр гэдгийг батламжилсан. Төвдийн "Шис-бя" хэмээх нэгэн сэтгүүлд энэ тухай нэгэн мэдээ нийтлэгдсэн байна. Төвдүүдийн мэдээлснээр Монголын албаны болон хувь хүмүүс Далай ламд "бусдын хүсэлт"-ийг дамжуулсан байна. Монголын Зохиолчдын Эвлэлийн дэд дарга Ж. Бямба, Монголын Ардчилсан Намын дарга Баасан лам нар 1991 оны 11 дүгээр сарын 29-нд Шинэ Дели хотноо Далай ламтай уулзах үедээ Жавзандамбыг сураглаж, түүнийг Монголд урих хүсэлтэйгээ илэрхийлжээ. Халхын "9 дүгээр Богд"-оор нэгэн төвд хүн тодорч, Энэтхэгт амьдарч буй нь үнэн болохыг Далай лам бээр нотолсон. Тэрээр Жавзандамбыг Монголд урих нь зөв гэж бодож буйгаа илэрхийлсэн ч түүнийг улс төрөөс холхон байлгаж, зөвхөн шашны асуудалд л зориулахыг зөвлөсөн байна. Түүнийг Монголын ард түмэнтэй танил дотно болгохын тулд Монгол уруу албан ёсны урилгатайгаар илгээх нь утга төгөлдөр гэжээ.

9 дүгээр Жавзандамбын тухай мэдээ тархсаны хойно Монголын хэвлэлд 1991 онд хоёр өгүүлэл нийтлэгдэж, егөөдсөн, зай барьсан байр суурь ажиглагдсан.<sup>37</sup>

1992 оны 3 дугаар сард Монголын нэгэн дээд зиндааны улс төрч Энэтхэгт Далай багштай уулзсан. Тэрээр Монголын иргэдээс Жавзандамбыг урьсан янз бүрийн урилгаас цэрвэж буй бөгөөд үүний цаана улс төрийн далд санаа байж болзошгүй талаар тодорхой өгүүлсэн байна. Бээжин үүнд илтэд дургүйцэж хариу барих вий гэдгээс Монголын албаны хүмүүс зовниж байлаа. Дээр дурдсан өгүүлэлд ярианы тэмдэглэлээс эш татсан болов уу. Үүнд Далай лам аминчилан доорх зүйлсийг ярьсан байна. Үүнд: "Богдыг Монголд залах талаар би жаахан өөр бодолтой байдаг. Богд Жавзандамба бол Монголын шашин, төрийг хослуулан барьж ирсэн түүхтэй. Монгол улс эрх чөлөөтэй байсан ч хуучин юм бүхнийг тэр хэвээр сэргээх албагүй. Есдүгээр Богдыг олон хутагт, лам нар нийлж тодруулсан. Монгол улс эрх чөлөөтэй болсныг харахдаа би энэ богдыг албан ёсоор зөвшөөрсөн. Энэ бүхнийг би шашны талаас нь анхаарч хийсэн бөгөөд улс төртэй ямар ч хамаагүй. Есдүгээр Богд Монголд богино ч гэсэн хугацаагаар очвол танай шашин, соёл сэргэн мандахад тус болох байх. Богд улс төрийн далд бодол сонирхолгүй бөгөөд Монголд удаан суурьших бодолгүй байгаа... Түүнийг Монголын зарим хүмүүс уриад байдгийг би мэднэ. Тодруулсны дараа нь ийм урилга ирэхэд Есдүгээр Богдыг танай шашны байгуулага богино хугацаагаар урьж аваачаад буцаавал зүгээр гэж санадаг. Түүнийг Монголын улс төрийн амьдралд оролцохгүй гэсэн баталгааг шаардлагатай бол би бичгээр гаргаж өгч болно."<sup>38</sup>

Жавзандамбыг тойрсон эдгээр асуудал нь шарын шашинтай сүсэгтэн олон болон ард түмний өдөр тутмын улс төрийн сонирхлыг онцгой ихээр татаагүй байв. Монголчууд болж буй улс төрийн өөрчлөлтөнд хөтлөгдөн сэтгэл хөөрч, өөрийн ард түмний түүхэн их Эзэн Чингис хаанаа эргэн дурсах болжээ. Монгол Улс тун удахгүй "Азийн бар"-сын нэг болно гэж Монгол Улсын Ерөнхийлөгч ярьж байв. Ингэхэд юуны өмнө шийдэж чадахгүй асуудал байхгүй мэт санагдаж байсан. Гэвч эдийн засаг унахын хирээр ард түмний дунд гутрангуй үзэл түгэж байв. Социализмын үед хэвшсэн ёс суртахууны зарчмуудыг хэрэгсэхгүй болсон бөгөөд шинэ зарчим хараахан гараагүй байлаа. Хүн амын ихээхэн хэсэг нь эрс ядуурч, өршөөлгүй хатуу нийгэм бүрэлдэн бий болохын зэрэгцээ гэмт хэрэг огцом өсөж байсан нь хүмүүсийг бүрэн туйлдуулсан. Хөгжлийн эдгээр олон үзэгдлийг шилжилт хийж яваа хуучин социалист системийн бусад орнуудад ч бид бас ажиглаж болно. "Ватиканы сүсэг бишрэлийн асуудлыг хариуцсан мэргэжилтэн" тэр үеийн Кардинал Ратцингер маш оновчтой бичсэн байна. Тэрээр "өдгөө бүх зүйл улам доройтон буурч байна, учир нь бид бөхөж буй үзэл суртлын оронд тэтгэн сэлбэгч сэтгэлийн хүчийг бий болгох чадваргүй юм"<sup>39</sup> гэжээ. Ийм нөхцөлд олон монголчууд шарын шашинд илүүтэй хандах болсон. Гэвч шашны хүрээнийхэн дотор бишрэл төрүүлэхүйц ихэс

<sup>37</sup> Т. Ганди, *Есдүгээр Богд тодрох уу?*, Ардын Эрх, 13.07.1991; Ш. Уянга, *Есдүгээр Богд хэзээ тодрох вэ?*, Ардын Эрх, 23.07.1991.

<sup>38</sup> Г. Ганболд, *Есдүгээр Богд гэж хэн бэ?*, Ардын Эрх, 12.04.1995.

<sup>39</sup> Joseph Kardinal Ratzinger, *Präfekt der Glaubenskongregation im Vatikan, Die Macht der Moral hat nicht abgedankt*, Welt am Sonntag, 11. April 1999

дээдэс илт үгүйлэгдэж байлаа. Далай лам болон Бакула гэгээнийг залан ирүүлэхэд бүгд анхаарлаа хандуулж байв. Бакула багш олны бишрэл хүндэтгэлийг хүлээсэн бөгөөд түүний үгийг хүмүүс анхааралтай сонсох болжээ.

## II үе шат - Жавзандамба монголчуудын ухамсарт алхам алхмаар нэвтэрч эхэлсэн нь

1993 оны 5 дугаар сарын 1-нд уран бүтээлчид болон сэхээтнүүд түүний дотор 8 дугаар Жавзандамбын өргөмөл хүү нь Улаанбаатарт Богдын санг<sup>40</sup> үүсгэн байгуулсан. Уг сангийн гишүүд нь Богд Гэгээний ордны цогцолборыг тордож, Жавзандамбын намтрыг судлах явдлыг эн тэргүүний зорилт хэмээн тодорхойлсон. Сэхээтнүүд болон бизнесийн хүмүүс дээрх сангийн ар талын санхүүжилтын 90 хувийг хийж, дэмжлэг үзүүлж байлаа.

1994 онд дээрх сангаас эрхэлж өмнөх Жавзандамбын амьдралыг харуулсан "Богд минь өршөө" хэмээх сэтгүүлийг хэвлүүлэн гаргасан. МАХН-ын хэвлэл болох Үнэн сонинд Жавзандамбын намтрыг судлах асуудлыг анхлан дэвшүүлэн тавьсан. 1994 оны 8 дугаар сарын 30-ны Үнэн сонинд Лха. Дарьсүрэн ийнхүү шаардаж бичсэн нь: "Үнэнийг хэлэхэд, эдүгээ Манжийн түрэмгийлэлийн эсрэг тэмцэж явсан Монголын зарим хутагт хувилгаадын тэмцлийн түүхийг сэргээн тодруулж, Монголын түүх судлалыг олон жил сүүдэртүүлсэн бараан толбыг гялтайлгах цаг хэдийнээ хаяа дэрлэчихээд байгааг бид анхаарах ёстой бус уу!"<sup>41</sup> Өмнөх Жавзандамбууд нэн ялангуяа 8 дугаар Жавзандамбын тухай эрчимтэй судалснаар нь түүний дараагийн хувилгаан дүрийг тодруулах асуудлыг зайлшгүй хөндөх болжээ. Энэхүү дүр нь монголчуудын дунд өсөн нэмэгдэж буй үндэсний ухамсрын улмаас монгол хүн байх ёстой нь дамжиггүй байв. 1926 онд нэгэн монгол хүнийг 9 дүгээр Богдоор тодруулж батламжилсан нь Монголын сүсэгтэн олон түмэнд төдийлөн танигдаж мэдэгдэлгүйгээр өнгөрсөн болов уу.

"Есдүгээр Богд Жавзандамба Энэтхэгт байдаг гэсэн. Тэр хүний биед үнэхээр Наймдугаар гэгээний сүнс оршдог гэдэгт итгэх ямар үндэс бий вэ?" гэсэн асуултанд хариулж Бакула 1995 оны 1 дүгээр сарын 13-нд сонинд ярилцлага өгөхдөө: "Энэ бол хариулахад тийм ч амар асуулт биш л дээ. Гэхдээ би Жавзандамба хутагтыг яах аргагүй Энэтхэгт төрсөн гэдэгт итгэж байна. Яагаад гэвэл IX Жавзандамбад өргөмжлөгдсөн тэр хүн суралцах хугацаандаа VIII гэгээний бүхий л шинжийг давтаж байсан юм. Зүгээр нэмж хэлэхэд, Богд хааны тухай ойлголтыг шашны гэгээн хэмээх ойлголттой ямар нэг байдлаар хутгах санаа надад үгүй юм шүү."<sup>42</sup> Асуултыг цааш лавшруулбал асуудлын харин нөгөө тал болох улс төрийн хэсэгт халтиран орох нь хариултын төгсгөлд бага зэрэг хачин санагдаж болох юм. Бакула багшийн хэлсэн энэхүү үгсийг монголчууд дуулгавартайгаар дагасан юм. Ийнхүү түүнийг 9 дүгээр Жавзандамба гэдгийг хүлээн зөвшөөрөх болсон. Цаг хугацааны хувьд эцэст нь Жавзандамба Монголд ирсний дараа хоёрдахь асуулт зайлшгүй урган гарч ирэх байлаа.

1996 оны 9 дүгээр 11-ний өдрийн *Засгийн Газрын Мэдээ* сонин тэргүүн нүүрэнд Монголын Сүсэгтний Холбооны мэдэгдэл нийтлэгдсэн байв. "Сүсэгтэн олон, сүм, хийд болон Монголын шашны байгууллагуудын хүсэлтээр" 9 дүгээр Богд Жавзандамба энэ оны 10 дугаар сард Монголд морилон ирэх болсныг уг холбооноос сонордуулсан байлаа. Хэрвээ 9 дүгээр Богд 10 дугаар сард ирвэл Гандан хийд дэх Улсын шүтээн Мигжид Жанрайсигийг шүншиглэх ёслолд оролцох болно гэдгийг Монголд хүн бүхэн тааварлаж байв. Энэ нь шинэ эвслийн Засгийн газрын зарим албаны хүмүүсийн толгойны өвчин болсон юм. 8 дугаар Жавзандамба нэгэнт Их Хүрээнд (хожим Нийслэл хүрээ, Улаанбаатар) суудаг байсан бөгөөд Улсын шүтээн байрлах Гандан хийд дэх урьдны алдартай шарын шашны дацан сургуулиудыг Жавзандамба удирддаг байжээ.

30-аад оны үед сүм, хийдийн өмч хөрөнгийг шударга бусаар хурааж авсныг эгүүлэн олгох асуудлаас Монголын Засгийн газар 1990 оноос хойш цааргалан зайлсхийж байсныг харгалзан үзэхийн зэрэгцээ өнгөрсөн түүхийг сөхөн үзвэл Жавзандамба нь "төр, шашныг хослуулан барих" эрхийг өөрийн биедээ хаа нэгэнтээ ямар нэгэн хэмжээгээр агуулсан (тус

<sup>40</sup> Идэвхтнүүдийн хүрээнд 8 дугаар Богдын өргөмөл хүү болох хөгжмийн зохиолч Л. Мөрдорж, С. Доржпалам, Д. Дамидмаа зэрэг уран бүтээлчид, УБХ-ын дарга асан Л. Дашням, Ш. Багцэнгэл, бизнесмен З. Түмэн-Өлзий нар багтаж байна. Гадны спонсорлогч нарт Япон-Монголын найрамдал, соёлын нийгэмлэгийн ерөнхийлөгч Абэ Жуна, Гүмпен лам Ганче Ринбүүчий болон лам Данзан Замаев нар орно.

<sup>41</sup> Лха. Дарьсүрэн, *Тусгаар тогтнолоо дээдэлсэн хутагт хувилгаад*, Үнэн, 30.08.1994.

<sup>42</sup> "АЭ"-ийн уншигчдад зориулж шүлэг бичлээ, Ардын Эрх, 13.01.1995.

улсын шүтээний) "гэрийн эзэн" биш байсан гэж үү?! Түүнд төрийн шүтээнийг шүншиглэх ёслолд оролцох боломж олгох нь өөрийн улсын ард түмэнд төдийгүй БНХАУ-ын Өвөр монголчуудад ч гэсэн элдэв санаа, сэтгэгдэл төрүүлэх вий. Олон түмний санаа бодлыг сонсолгүйгээр Жавзандамбыг дахин олны өмнө гаргаж ирсэн. Монголын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл асуудалтай тулгарсан. 9 дүгээр Богдын хувьд хувилгаан тодруулсан дэглэм тодорхойгүй байсан тул түүнийг Монголд айлчлахад виз олгохгүй байх шийдвэр гаргахад хүрчээ. Гадаад Яам Шинэ Делид байгаа Элчин Сайдын Яамандаа зохих зааврыг өгсөн байв. Үүнээс хойш 9 дүгээр Богдын тухай яриа тасарсан.

Гэвч Богдын сан, Гандан хийд нь Жавзандамбыг Монголд урих зөвшөөрөл олгохыг Засгийн газраас гуйж байлаа. Монголын Төвд судлалын Төв, Монгол-Төвдийн найрамдлын нийгэмлэг, Буддын судлалын Норовлинга-Институтын салбар болон ЮНЕСКО-ийн үндэсний байгууллагуудын холбооноос өргөдөл хүсэлт ирсээр байв. 1998 оны 2 дугаар сард Монголын ГХЯ дээр болсон уулзалтан дээр Хамба Чойжамц Монголд 10 дугаар Богдыг тодруулахын тулд IX Богдыг хүлээн зөвшөөрч Монголд оруулах нь тун чухал. Эс тэгвээс дараагийн Богдыг Хятадад тодруулж болзошгүй аюулыг тэрээр урьдчилан харсан болов уу. Үүнтэй холбогдуулж тэрээр магад "Ерөнхийлөгч саарал ордондоо Богд нь Гандан дээрээ заларч, хоорондоо тэнцүү харилцаж бас бие биеэ хүндэтгэн үзэх"<sup>43</sup> гэжээ. Хэрвээ Чойжамц үнэхээр тэгж хэлсэн бол түүний эдгээр өгүүлбэрээс авч үзэхэд тухайн хүний дотоодод асар их тэсрэлт явагджээ гэсэн дүгнэлтэнд хүрч болохоор байна. 1998 оны зун 20 лам (түүний дотор өмнө дурдсан Баасан лам байв) Улаан-Үүд (Буриад)Орос) явж, 9 дүгээр Богдтой уулзсан байна.

Үүний дараахан буюу 1998 оны 9 дүгээр сарын 7-12-нд Азийн Буддистуудын Энх Тайвны Бага Хурал Улаанбаатар хотноо зохиогдсон бөгөөд үүнд уг хурлын ерөнхийлөгч Бакула багш уг хэлэхдээ: "Бид шинэ мянганд ормогцоо ирээдүй үеийнхээ төлөө их хариуцлага өвөрлөнө. Байгаль орчныг хамгаалан хадгалах хэрэгцээг ард түмэн, ялангуяа залуучуудад ухааруулах анхдах үүрэг байх ёстой. Сүүлийн жилүүдэд Азийн хэсэг хээхэн өөрчлөгдлөө. Буддистууд бидний хувьд хүн төрөлхтөнд шинэ амгалан үе нь баясгалант бэлгэдэл юм. Бурханы шашны өрнөдөд дэлгэрч байхад бурханы шашин Азийн олон оронд өөрийн язгуур чанараараа цэцэглэж байна гэхээр аятай мөч билээ. Бид одоо үймээн түйвээн, балмад танхайг харж байна. Олон оронд бурханы шашин тэр орныхоо соёлын салшгүй хэсэг болсон тул бурханы шашны доройтол нь үндэсний өвөрмөц чанараа алдана гэсэн үг юм"<sup>44</sup> гэжээ.

### III үе шат - 9 дүгээр Богд Монголд морилон ирсэн нь

Халимагийн Ерөнхийлөгч Илюмжиновын урилгаар 9 дүгээр Жавзандамба 1999 оны 7 дугаар сард Халимаг (ОХУ) руу явсан. 1999 оны 7 дугаар сарын 22-нд тэрээр Москвад суугаа Монголын ЭСЯ-ны консулын ажилтан Б. Энхбаяраас 30 хоногийн хугацаатай жуулчны виз авсан. Консулын газар тэрээр өөрийгөө Энэтхэгт цагаачлан амьдарч буй Жампил Намжил хэмээн танилцуулсан бөгөөд өөрийн нутгийн хүн болох Чойжил-Юндэнг дагуулан явж байгаа гэжээ. Монгол Улсын иргэн Л. Баясгалан болон Чимгээ (Баянзүрх дүүрэг, Улаанбаатар) нарын гарын үсэг бүхий хувийн урилгыг тэрээр үзүүлсэн байна. 9 дүгээр Богд 1999 оны 7 дугаар сарын 13-нд Монголд нэвтрэн ороход Монголын Гадаад Харилцааны Яамны ажилтнууд түүнийг Монголоос гарч явахыг шаардсан. Уг яам Богдын аяллын хөтөлбөрийн тухай мэдээллийг хэдийнээ авсан байв. Богд тэдгээр ажилтанд Халимагт суугаа Монголын консул Ш.Будбаярын урилгыг үзүүлж, үүнийг Монголын Засгийн газрын албан ёсны урилгатай адилтган үзэхийг нотолж байв. Үүний үндсэн дээр түүнийг Монголд нэвтрүүлжээ. Баталгаатай эх сурвалжаас үзэхэд дөнгөж 7 дугаар сарын 13-нд л Гандан хийдийнхэн Богд морилон ирсэн тухай сураг сонссон байна. Тэд айлчлалын хөтөлбөрийг зохиохын тулд 3 хоног зөвлөлдсөн байна. Хөтөлбөрийг зохиож, нийтээр зөвшөөрсөн боловч, зарим хүрээ хийдийн тэргүүн нарын үйл ажиллагаагаар уг хөтөлбөр ёсоор болж чадсангүй. Үүнд Эрдэнэ Зуу хийд, Амарбаясгалант хийд хоёроор айлчлуулахаар төлөвлөсөн байсан бөгөөд 8-р сарын эхээр Эрдэнэ Зуу хийдэд ерийн

<sup>43</sup> Д. Баярхүүгийн ишлэлээс авлаа. *Түвдийн засаглалыг Монголд хуулбарлажээ, Монгол дахь шарын шашны хямрал ба 9 дүгээр Богдын засаглал*, Өдрийн Сонин, 29.09.1999.

<sup>44</sup> Speech delivered by Ven. Kushok Bakula, President of the ABCP, at the 9<sup>th</sup> Conference held from September 7-12, 1998, Ulaanbaatar.

айлчлалт хийх байсан боловч зөвлөгөөнөө зөрчиж, Жавзандамба хэмээн албан ёсоор зарлан, албаны тамга гардуулсан нь байдлыг улам хүнд болгожээ.

Гэвч 9 дүгээр Богд 7 дугаар сарын 18-нийг хүртэл олон нийтийн өмнө гарч ирсэнгүй. БНХАУ-ын Ерөнхийлөгч Зян Зэминь 7 дугаар сарын 18 хүртэл Монгол Улсад албан ёсны төрийн айлчлал хийсэн бөгөөд дипломатын хувьд эвгүй байдалд орохоос хүмүүс эмээж байлаа. Зян Зэминь Монголд байх үеэр олны өмнө гарахгүй гэдгээ Богд өөрөө илэрхийлсэн байна. 7 дугаар сарын 19-нд *Өдрийн сонин*-д Богдтой хийсэн ярилцлага нийтлэгдсэн. Богд гэгээн өөрийн аяллынхаа талаар танилцуулж, янз бүрийн асуудлыг хөндөж ярьж байв. Тэрээр Төвд, Монголыг "Шарын шашны ноён оргилууд" хэмээн тодорхойлж, "VIII Богд бол Манжаас Монголыг тусгаарлахад гавъяа байгуулсан хүн" гэжээ. 10 дугаар Богдыг Монголоос тодруулах эсэх талаар асуухад тэрээр хариулахдаа: "Олон түмний тусын тулд Богд тодрох нь зөв. Гэхдээ хаана вэ гэдэг нь чухал. Өндөр гэгээний урьд дүр Жонон Дарнат хойд дүрээ Монголд тодруулахыг хүссэн. Ёсоор болгосон. I, II Богд Монголд тодорсноос хойш бүх Богд Төвдөөс тодорсон. Гэхдээ сүнс, тангараг нийлж, зохилдох шалтгаан бүрдвээс Монголоос тодорч болохыг үгүйсгэхгүй."<sup>45</sup> гэсэн байна. Дараагийн өдрүүдэд Богд Гандан хийдийн Дашчойлон хийд, Дүйнхор дацанд морилж, сүсэгтнүүдийнхээ өмнө заларсан. Ард олон түүнийг нэн хүндэтгэлтэйгээр хүлээн авсан.

7 дугаар сард Далай ламын төлөөлөгч Жадо Ринбүүчий Монголд ирээд Гандан хийдийн хамба лам Чойжамцын хамт Архангай аймаг руу явсан ба тэнд тэд Далай ламын тамга бүхий захидлыг задалсан бөгөөд 1972 онд Цэцэрлэгт төрсөн Самбуугийн Баяртайг<sup>46</sup> Зая Гэгээний 6 дугаар дүрээр тодруулсан байна. 1990 онд Далай лам 5-25 насны 500 монгол хүүхдийн нэр, хаягыг цуглуулж, тодорхой шалгуураар 16 хүртэл цөөрүүлж, эцэст нь үлдсэн нэг хүүхдийг хувилгаанаар тодруулжээ. Энэ мэдээ хэдээнээ дуулиан болон дэгдэх ёстой атал Монголын хэвлэлд энэ талаар бараг юу ч гарсангүй. Хэзээд ам хуурай байдаггүй Монголын хэвлэл хувилгаан тодруулсны хойно ч энэ тухай үг цөөтэй өнгөрөөсөн юм.

8 дугаар сарын 5-нд Богд Өвөрхангай аймгийн Эрдэнэ-Зуу хийдэд хүрэлцэн ирсэн бөгөөд тэрээр ийнхүү онцгой газар шорооноо хөл тавьсан. Энд 1 дүгээр Жавзандамба Өндөр Гэгээн Занабазар үйл хэргээ явуулж, энд мөн Занабазарын эцэг Түшээт ханыг оршуулсан билээ. Хийдийн хажуухан Монголын Эзэнт Их гүрний нийслэл Хархорин нэгэнтээ оршиж байв. Эрдэнэ Зууд айлчлуулах үед Бурханы шашны мандал өргөх зан үйлийн явцад зарим лам тамга өргөж, "Богд" хэмээн өргөмжилсөн. Энэхүү бэлэг дэмбэрэлтэй газар Мэндбаяр, Нацагдорж, Дамбажав ламтан нарын зохион байгуулсан Бурхан шашны Чуулган чуулж, "Халхын цагийг эзэлсэн Богд Гэгээн 9 дүгээр Жавзандамба хутагтыг" Монголын шарын шашны тэргүүнээр тодруулсан. Дашдоржийн Баярхүү тус чуулганы тухай нарийн мэдээллийг тодорхой нэг байгууллагын захиалгаар сонинд нийтлүүлсэн бөгөөд түүний энэхүү полемик маягийн өгүүлэлд магадгүй Монголын Засгийн газрын байр суурь тусгагдсан байх. Энэ өгүүлэлд бичсэнээр "Ерөнхий Чуулган" (Нарийн бичгийн дарга Амгалан лам)-ы зэрэгцээ Эрдэнэ-Зууд болсон үйл явдлын талаар Д.Баярхүүгийн бичсэн нь үнэн байдалд нийцээгүй байдаг.<sup>47</sup>

Эрдэнэ-Зууд болсон мандал өргөх ёслолын дараа лам нарын шашны хүрээн дэх үйл ажиллагаа цаашид идэвхжсэн байна. Дипломат алба хашдаг боловч Богдоос цэрвэлгүй харилцаж байна уу даа гэх сэтгэгдэл төрүүлэх Бакула хувилгаан Бэтүб Данжай Чойнхорлин хийдийн нээлтийг (уг нээлтэнд Энэтхэгийн дэд зөрөнхийлөгч Кришан Кант оролцсон) тохиолдуулан хэлсэн үгэндээ Монголын залуучуудад Бурхны шашин хэрэгтэй болохыг сануулсан бөгөөд "Нэгэнт өвөг дээдсийнхээ олон зуунд шүтэж ирсэн, бурхны шүтээн, түүх, соёлоо хүндэтгэх учиртай... Гуравт, олон янзын шашин руу явж сэтгэл санаа хоёрдоод байвал өвөг дээдсийнхээ түүх, соёлыг гэж, түүгээр ч барахгүй улс орныхоо тусгаар тогтнолыг алдаж

<sup>45</sup> Сэрүүн Богд талын Монголд, Өдрийн Сонин, 19.07.1999.

<sup>46</sup> С. Баяртажийн намтар: Аав нь модны үйлдвэрийн ажилчин, Ээж нь 3 настай байхад нь нас барсан, 5 ах дүүтэй, 8 дугаар анги төгсөөд цэргийн алба хаасан, мал маллаж байсан, шарын шашны боловсролгүй, 1992 онд найз нарынхаа зөвлөснөөр лам болохоор эрэгцүүлэн бодож эхэлсэн, үүний дагуу Улаанбаатар дахь Шашны дээд сургуульд элсэж орсон, тэндээ тэрээр үлдэж Улаанбаатарт шашны боловсрол эзэмшиж байна, дараад нь Далай лам дээр очно. Зая бандидын долоо дахь дүр тодорлоо, Өдрийн Сонин, 31.07.1999.

<sup>47</sup> Д.Баярхүү, Түвдийн засаглалыг Монголд хуулбарлажээ, Монгол дахь шарын шашны хямрал ба IX Богдын засаглал, Өдрийн сонин, 29.09.1999.



болох юм."<sup>48</sup> хэмээжээ. Монголчууд өөрийн орных нь тусгаар тогтнолын тухай ярихад маш эмзэг хүлээн авдаг. Үүнийг Бакула багш маш сайн ойлгосон бололтой. Ингээд Гандан хийдийн хамба лам, Далай ламын цагаач Засгийн газар, Монголын Засгийн газар хоорондоо бичгээр идэвхтэй харилцсан. Жавзандамбыг эгүүлэн татахыг Монголын Засгийн газар Далай ламаас магадгүй дахин дахин шаардаж байсан. Ямар ч атугай түүний визийн хугацаа хэдийнээ дууссан байлаа. Энэ бол асуудлын зөвхөн нэг тал нь байсан бөгөөд нөгөө тал "дотоод асуудалд хөндлөнгөөс оролцсон" гэдэг үгээр тайлбарлагдаж байсан бөгөөд энэ нь хугацаа дууссан визийн тухай зөвхөн яригдаагүйг харуулж байна.

8 дугаар сарын 16-нд Улаанбаатарт Жавзандамба хэвлэлийн бага хурал хийх үедээ иймэрхүү зүйлд хариу өгөхөөр шийдсэн бололтой. Тэрээр "Миний энэ айлчлал ямар ч улс төрийн зорилго агуулаагүй..."<sup>49</sup> гэж тайлбарласан.

Монголын хэвлэл уг асуудлыг хэт их дэлгэн харуулж байлаа. Монголын хэвлэлд Гандан хийд болон Далай ламын Засгийн газрын факс-захианы хуулбарууд сонин хэвлэлийн тэргүүн нүүрэнд гарах болсон. Дээрх хуулбарт дурдсанаар "Богд Жавзандамбын манай улсад эзлэх шашны статусын тухай албан ёсны тогтоол шийдвэрийг" хүлээж байгаа тухайгаа 8 дугаар сарын 23-нд Гандан хийдийн хамба лам Чойжамц Далай ламд мэдэгдсэн байна. Энэ шалтгааны улмаас ч түүний буцахыг хойшлуулсан гэжээ. Монголын Засгийн газрын үйл ажиллагаа Монголын олон нийтэд огт анзаарагдалгүй өнгөрсөнгүй бөгөөд магадгүй үүнийг эсэргүүцсэн нийтлэлүүд гарах болсон. Мөн 8 дугаар сарын 7-нд "Зууны мэдээ" сонин 9 дүгээр Богдыг ямар нэгэн далд санаатайгаар "Зууны манлай шашны удирдагч" хэмээн өргөмжилж, Гандан хийдийн төлөөлөгчид мөн өдөр сүсэгтэн олноос цугласан 2,5 сая төгрөгийн хандивийг Богдод барьсан. 9 дүгээр 14-нд "Өдрийн сонин" ярилцлага өгөх боломжийг Жавзандамбад олгосон. Монголын Засгийн газар түүнд хэрхэн хандаж буй талаар асуухад Богд хариулсан нь: "Төр засгаас намайг ирсэнтэй холбогдуулж хүрээ хийдэд элдэв янзын саад садаа хийгээгүй байх. Чухам төр засаг ямар бодолтой байдгийг би яаж мэдэхэв." Сэтгүүлчид цааш лавшруулан асуусан нь: "Таныг Монголд удаж, шашны тэргүүнээр өргөмжилсөнд Далай лам таагүй байгаа тухай яригдах юм. Тэр бүү хэл, түргэн ирэхийг шаардсан ч гэх шиг." Хариулт нь товч бөгөөд тодорхой байв: "Далай багш намайг дуудаагүй."<sup>50</sup>

Богд Энэтхэг рүү буцаж байгаа тухай мэдээ төдий удалгүй 9 дүгээр сарын 17-нд Монголын хэвлэлд гарчээ. Тэрээр Оросоор дамжин харих замыг сонгосон байна. Гандан хийдийн дэд хамба Ё. Амгалан лам, Б. Гүндсамбуу лам нар түүнийг дагалдан явж үдсэн. Богд дараа жилээс Монголд ирж суух санаатай байгаа тухай хэвлэл дээр мөн мэдэгдсэн байна.

*Зууны Мэдээ* сонины 1999 оны 10 дугаар 13-ны дугаарт УИХ-ын гишүүн, МАХН-ын дарга, Монгол-Энэтхэгийн найрамдлын нийгэмлэгийн дарга Н. Энхбаяр, Монгол улсаас БНЭУ-д суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд О. Нямдаваа нарыг далай ламтай уулзсан тухай бичихдээ:

"1. Монгол Улсын улс төр, эдийн засгийн байдлыг сонирхон, мөн бурхан шашны онол орчин үеийн шинжлэх ухаантай хэрхэн зүйн хэлхээ холбоотойг тайлбарлаж чадах олон сайхан эрдэмтэд өрнөдийн оронд байдгийг тэмдэглээд тэдгээр хүмүүсээр Монголын залуучуудад лекц уншуулж болохыг онцлон тэмдэглэв. Бурханы шашин шинжлэх ухааны үндэслэлтэйг тайлбарлан таниулж чадах олон эрдэмтэн Монголд байдаг. Тэд нарынхаа үгийг сайн сонсож ойлгох цаг Монголд бий болж байгааг мөн айлдав. Цааш нь, Халхын Жавзандамба Оросын нутгаар явна гэж гараад Монгол руу өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр сэм очиж, Монголын Засгийн газрын дэмжлэг авалгүй, дотоод байдалд нь хутгалдан визийн хугацаагаа хэтрүүлснийх нь төлөө түүнийг эгүүлэн дуудсан гэдгээ давхар нотлов. Тэрээр Халхын Жавзандамбын энэхүү хууль бус үйлдлийг буруушаагаад, Монголд түүнийг дахин очуулахгүй, Монголын дотоод хэрэгт Түвдийн цагаачид, тэдний хөөгдмөл Засгийн газар оролцохгүй, оролцох сонирхол ч үгүй, тэрхүү Богдыг Энэтхэгт буцаж ирмэгц нь арга хэмжээ авна хэмээн мэдэгдэв.

<sup>48</sup> Ш. Цэрэнпил, *Гэгээн хутагт санасан хэрэгээ гүйцэтгэлээ*, Өдрийн Сонин, 1999.

<sup>49</sup> *Би улс төрийн зорилгоор ирээгүй*, Өдрийн Сонин, 1999.08.20.

<sup>50</sup> *Би улс төрийн зорилгоор ирээгүй*, Өдрийн Сонин, 17.05.1999

2. Өртэй жижиг буурай орнуудын өрийг хүчингүй болгож, 2000 онд шилжин орохдоо өргүй болгох хөдөлгөөнийг сүүлийн үед өрнөдийн орнуудын улс төр, соёл урлаг, шашны нэрт зүтгэлтнүүдээс өрнүүлж түүнд Далай лам нэгдэн оролцож гарынхаа үсгийг зураад байгаа юм байна. Иймд тэр хөдөлгөөндөө Монгол Улсыг хамааруулж ОХУ-д төлөх ёстой Монголын өрийг хүчингүй болгоход туслах хүсэлтийг УИХ-ын эрхэм гишүүн Н. Энхбаяр Далай ламд тавив.<sup>51</sup>

Монголд Улсад суугаа БНЭУ-ын ЭСЯ-ны нарийн бичгийн даргын мэдээлснээр Энэтхэгийн элчин сайд Бакула Ринбүүчий энэ оны 12 сард Монголоос бүрмөсөн нутагтаа буцах болсон тухай *Өдрийн Сонин*-ы 1999 оны 10 дугаар сарын 28-ны дугаарт мэдээлжээ.

Ингэснээр "Монголд ясаа тавих" гэсэн Бакула багшийн хүсэл биелсэнгүй. Бакулагийн хувилгаан дүр умар зүгийн ард түмнийг шашинд оруулахын тулд хойд зүг одно гэдэг нь ийнхүү нэг мөр биелсэнгүй.

## Дүгнэлт

Жавзандамбыг тойрсон асуудлуудыг анхлан харахад цэвэр шашны хэрэг мэт бөгөөд энэ нь визийн хугацаа хэтрүүлснээр л хууль эрхийн агуулгатай болж ирсэн. Гэвч энэ нь Монголын хуулийг зөрчсөн төдий бус бөгөөд Монголын Засгийн газрын зарим албан тушаалтнууд Монголын үндсэн хуульд заасанчлан төр, сүм хийд хоёр нь ангид байх зарчмыг тодорхой тохиолдолд хөндөж чадахын тулд гуравдагч талын зөвлөгөөг харгалзан бусад шалтгааныг хайж олох ёстой байсан болов уу.

Зөвхөн Улаанбаатарт л гэхэд цөөн бус тооны христосын сүм байрлаж, Монголын хэвлэл мэдээллийнхэнд чичүүлэлгүйгээр аль нэг үндэстний "5 дугаар колонн" болж буйгаас авч үзэхэд монголчуудын уламжлалт шашны гол этгээд болох Жавзандамбатай харьцаж буй харьцаа нь гайхал төрүүлмээр байна. Ийнхүү гайхал төрүүлж буй нь хоёр шалтгаантай юм. Үүнд нэг талаас Монгол Улсын Үндсэн хуулинд "Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ."<sup>52</sup> гэж заажээ. Үүнийг хэл зүйн үүднээс авч үзэхэд бүгд ганц тоон дээр бичигдсэн байна. Тэгвэл шашин гэж заасан нь шарын шашинг хэлсэн болов уу. Нөгөө талаас 1993 онд батлагдсан төр, сүм хийдийн харилцааны тухай хуулинд "шашныг гаднаас зохион байгуулалттайгаар оруулахыг хориглоно"<sup>53</sup> гэсэн заалт бий.

Тэр үед Монголын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн дарга асан Р. Болдын хэлснээр монголчуудын 60 хувь нь шарын шашинтай байсан. Энэ тоо хэт их мэт санагдаж магадгүй гэвч үүнд уламжлалаа дээдэлж, шарын шашнаа шүтдэг хүмүүс багтаж байгаа юм. Тэдний хэнд ч Жавзандамбыг энэ нутгаас хөөн зайлуулах санаа төрөхгүй байх. Уламжлалаас үзэхэд түүнийг тодруулж ирсэн арга туршлагаас заримыг нь онцолж болох хэдий ч үүнийг Далай ламаар ямагт батламжлуулсаар ирсэн бөгөөд шарын шашинд Далай ламаас өөр эрхэм дээд нь үгүй билээ. Гэвч олон монголчууд хоёр зүйлийг илүүтэйгээр сонирхож байсан.

1. Жавзандамба Монголд үлдсэн тохиолдолд түүний хувилгаан дүрийг монголчуудын дундаас тодруулах боломж бий болно. Энэ нь шинэ боломжийг нээж өгөх бөгөөд Далай лам дахин хувилгаан дүрийг үзүүлэхгүй хэмээн хэлэх тийм цаг үед ч мөн адил шинэ боломж олгоно. Жавзандамба шиг шашны ийм нэр нөлөө бүхий этгээд Монголын бие даасан сүм хийдүүдийн хамба нарын тэмцэлдээн өрсөлдөөнийг дуусгавар болгож чадах болов уу.
2. Үндэсний Жавзандамбын бэлэгдлийн хүч чадал дундаршгүй их билээ. Энэ хүч чадал нь ямагт Монголын төрийн ноён нуруу болсоор ирсэн ард олныг бэхжүүлдэг билээ.

Улаанбаатар дахь Монголын армийн торгон цэрэг нь Монгол Улсын дээд бэлэгдэл болсон их цагаан тугийг залан явах бөгөөд уг тугийг он удаан жил өвлүүлэн хадгалсны дээр 1206 онд Богд Чингис хаан Эзэнт Их гүрнийг үүсгэн байгуулах үедээ мандуулан явж байжээ.

<sup>51</sup> Далай лам IX Богдыг Монголд очуулахгүй гэж айлдав, Зууны Мэдээ, 13.10.1999.

<sup>52</sup> Монгол улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд (1924-1992), Улаанбаатар 1998, 85-р тал.

<sup>53</sup> Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, Улаанбаатар 1993.

Монгол Улсын Ерөнхийлөгч жил бүр уул-тахих төв ёслолд оролцохын зэрэгцээ Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга Монголын цагаан сарын баярыг тохиолдуулан жил бүр төрийн шүтээн болох Мигжид Жанрайсигт ирж мөргөдөг. Уламжлалаа ингэж сайтар дагаж буй үед Жавзандамбатай нягт харилцаатай байх нь боломжтой зүйл мэт. Ийм боломж үгүй гэх аваас монголчууд янз бүрийн их гүрнүүдийн дунд "хавчуулагдсан халиуны зулзага адил" болсон юм уу. Үүнтэй холбогдуулж хэлэхэд Монголын Засгийн газрын зүгээс гуравдагч талын ашиг сонирхлыг харгалзах шаардлагатай бөгөөд үүнийг Монгол - Хятадын харилцааны хувьд ул суурьтай авч үзэх нь зүйтэй. Харин логикийн талаасаа 9 дүгээр Жавзандамбын тухай асуудалд ийнхүү болгоомжтой хандах нь зүйд нийцэхгүй болов уу. Чин улсын үеэс улбаатай шодох зарчмаар дараагийн Жавзандамбыг Хятад тодруулахыг хүсэх нь ойлгомжтой. Хятадын зүгээс энэ нь нарийн утга учиртай юм. "Хятад" Жавзандамба Дундад улсын хүсэл сонирхлыг "гадаад" монголчуудад ямагт шууд бусаар нялзаах байх. Гэвч ийм Жавзандамба нэг гол сул талтай байх. Тэрээр магад Жавзандамбын хэдийнээс морилон суудаг байсан Их Хүрээнд (өдгөө Улаанбаатарт) залран суухгүй байх. Харин зөвхөн Монголд байнга суух Жавзандамба бол Монголын Жавзандамба мөн билээ. Хэдий тийм боловч Монгол нь шарын шашны том төв болох аваас Хятад улсын ашиг сонирхолд нийцэх боломжтой мэт. Учир нь байдал хэрэв ийнхүү эргэвэл Төвдөөс заримт дарамт ирж магадгүй бөгөөд мөн газарзүйн босоо тэнхлэгийн дагуу магадгүй сонголт хийх боломжтой болох юм. Монголд шарын шашин дэлгэрэхдээ Буриад тухайлбал Байгалийн тэртээх нутгаас эхлэлээ авдаг. Буриадад эдүгээ шарын шашин сэргэн мандаж, биеэ дааж эхэлж байна. 1999 оны 10 сараас хойш Улаан-Үүдэд Бурхан шашны дээд сургууль ажиллаж байна. Түүний багш нар нь Улаанбаатар дахь Шашны Их Сургуулийг төгсөгчид юм. Монголын бурхан шашинтнуудын дэмжлэгтэйгээр Тувад дахин шарын шашин дэлгэрсэн. Оросын Чечень дэх дайн салан тусгаарлагчдын хөдөлгөөнийг дэвэргэвэл энэ нь Тува, Байгалийн чанадын нутаг өөрөөр хэлбэл Оростой хил залгаа Монголын нутагт орж ирвэл яах вэ? ОХУ-ын Ерөнхийлөгч В. В. Путин Оросын задралыг зогсоох тухай шаардлагыг олонтаа тавьсан шүү дээ. Үүнд мөн нэг аспект нэмэгдэж орох бөгөөд энэ нь Эрхүү муж болон Байгалийн бүс нутаг дахь хятад цагаачдын асуудал юм. Зөвлөлтийн үед хятад цагаачдын тоо цөөн байсан бол 90-ээд оны үеэс эхлэн хүмүүсийг хянах хуучин тогтолцоо нуран унасны улмаас Оросын албан тушаалтнууд үүнийг зохицуулах боломж үгүй болсон. Гэхдээ эдгээр хятад нь БНХАУ-ын иргэд болох агаад Орос, Хятад хоёр өдгөө ойртон дотносож, стратегийн түншлэл байгуулж буй тул Кремль энэ асуудлаар Бээжинтэй хатуу үгээр ярилцах үндэслэл багатай гэдгийг анзааралгүй орхиж болохгүй. Харин цаг хугацааны хувьд Оросын тус бүс нутагт амьдарч буй хятад цагаачдын тоо нэмэгдсээр байна. 1989 онд Оросын бүх нутгаар 489 хятад (үүнээс 185 нь Эрхүүд) сууж байсан бол хожим энэ тоо эрс өссөн. Зөвхөн Эрхүү мужид 40.000 орчим хятад хуулийн дагуу мөн тооны хятадууд хууль бусаар 1994 онд амьдарч байгааг Эрхүүгийн албаны хүмүүс ярьж байсан. Өнөөдөр энэ тоо эрс нэмэгдсэн шүү дээ. Үүний зэрэгцээ Орос-хятадын эрлийзүүд болон хотын их, дээд сургуульд элсэн суралцагч оюутнуудын тоо (1995 онд 1000 орчим) эрчимтэй нэмэгдэж байгааг Оросын албаны хүмүүс хэдийнээ ажигласан байна. Тодорхой хэлбэл оросоор ярьдаг бөгөөд Орост удаан хугацааны туршид амьдрахын тулд соёлын хувьд ямар нэгэн байдлаар дасан зохицож буй (гэвч өөрийн төрөлхи соёлын дүр төрхийг үнэн хэрэг дээрээ орхилгүйгээр) хятадуудын тоо эрчимтэй нэмэгдэж байна гэсэн үг юм. Энэ байдал зөвхөн Эрхүү мужийн нутагт бус харин түүнтэй хөрш зэргэлдээ газруудад ч хамаатай юм. Транссибирийн төмөр зам энэ өргөн уудам нутгаар дайран өнгөрдөг нь дээрх асуудлыг стратегийн асуудал болгож байна. (Тус бүс нутгийн уурхайчид олон жилийн өмнө ажил хаяж, Транссибирийн төмөр замын нэг хэсгийг түгжихэд тээврийн зам хаагдаж, Оросын Алс Дорнодын хангамж хэрхэн доройтохыг нүдний өмнө илтэд харуулсан.) Үлдэх хэсгийг логистикийн хэзрийн дагуу эрэгцүүлж мэдэхээс аргагүй бөгөөд үүнд шашны барилдлага сонирхолтой үүрэг ноогдох болов уу?

Хоёр хөршийнхөө аль нэгийг илүүд үзсэн нь Жавзандамбатай холбогдуулж илэрхийлэх албан ёсны байр сууринд нөлөө үзүүлсэн гэдгийг ойлгоход төвөгтэй юм. Гэвч даяаршил ба бүсчлэлийн хооронд хямралт бүс оршсоор байгаа бөгөөд үүнээс л Монголын улс төрийн өдөр тутмын хариу үйлдлийг тайлбарлаж болно. Жавзандамбаар зангидан удирдуулсан шарын шашин нь Монголыг урт богино ямар нэгэн хугацаагаар дахин арай илүүтэйгээр Азитай холбох байх гэсэн төсөөллийг зарим хүн тээж явдаг. Гэвч энэ нь юмыг хайрцаглаж энгийнээр боддог хүмүүсийн зөвхөн өнгөц төсөөлөл юм.

Бүс нутгийн харилцаанд Монгол Улс нь зөвхөн эх оронч үзэл эсвэл Монголоо гэсэн үзэл (mongolian self-identity)-тэй байж л улс төрийн хувьд сонирхолтой болох юм. Миний хувьд 90-ээд оны үеийн гадаад бодлогын хамгийн сайн баримт бичиг хэмээн үздэг 1994 оны "Монголын гадаад бодлогын үзэл баримтлал"-д "12.1. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд аль нэгийг нь ерөөсгөлөөр дагахгүй, бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ."<sup>54</sup> гэжээ. Энэхүү статусыг тогтоож байнга хадгална гэдэг бол Монгол Улс гуравдагч улс орнуудтай хамтран ажиллах үндсэн урьдач нөхцөл болох юм. Энэ нь Хаант Орос/ЗХУ/Орос болон Хятадтай харилцах монголчуудын түүхэн туршлагын үр дүн юм. Монголын үндэсний түүхийг мэдэх хүн бүхэн Монголын эх оронч үзэл нь асар том түлхэх хүч болдогийг мэдэх билээ. Өнөөгийн нөхцөлд авч үзэхэд монголчууд эх оронч үзлийг бэхжүүлэх нь "Азидаа бүрэн эргэж ирж буй" хэрэг биш (он удаан жилийн туршид үргэлжилсэн шашингүйн бодлого болон европчлох явцыг эргэж буцаах боломж бараг үгүй болов уу) харин гурван талт харилцаанд Монгол Улсын байр суурийг бататгаж буй явдал мөн. Ийнхүү бэхэжсэн байр суурь нь Монгол Улс, гуравдагч талын хоорондын эрх тэгш хамтын ажиллагаа болон Монгол дахь гуравдагч этгээдтэй Монголын төлөө хамтран ажиллах гол нөхцөл болох юм. Үүнийг зарим зөвлөгч нар ч нарийн бодоход илүүдэхгүй биз ээ.

---

<sup>54</sup> Гадаад бодлогын үзэл баримтлал, Төрийн Мэдээлэл 9(1994), 807-р тал.